

Сайнмэдээний Номууд

Хичээл 2

Матайн Сайнмэдээ

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Сайнмэдээний Номууд

Хоёрдугаар Хичээл

Матайн Сайнмэдээ

Агуулга

УДИРТГАЛ	1
ТҮҮХЭН НӨХЦӨЛ	1
Бичээч	2
Уламжлалт Үзэл	2
Хувийн Амьдралын Түүх	5
Анхны Хүлээн Авагчид	7
Тэнгэрийн Хаанчлал	7
Иудейн Ёс заншлууд	9
Үндсэн Шалтгаан	10
Огноо	11
Байршил	11
Зорилго	12
БҮТЭЦ БА АГУУЛГА	14
Удиртгал: Мессиа Хаан	15
Угийн бичиг	15
Нялх Үеийн Хүүрнэл	16
Хаанчлалын Сайнмэдээ	17
Мессиа Ирчхээд байна	17
Уулан дээрх Сургаал	21
Хаанчлалын Тэлэлт	23
Есүсийн Гайхамшиг ба Хариу Үйлдлүүд	23
Хааны Төлөөллүүд	25
Тэмдэг ба Сургаалт зүйрлэлүүд	26
Тэмдэг ба Хариу үйлдлүүд	26
Хаанчлалын Сургаалт Зүйрлэлүүд	27
Итгэл ба Агуу Байдал	29
Есүст Итгэхийг эсэргүүцсэн нь	29
Хаанчлалын Гэр бүл дэх Агуу байдал	31
Одоогийн Эсэргүүцэл ба Ирээдүйн Ялалт	32
Эрчимжиж буй Эсэргүүцэл	33
Ирээдүйн Ялалт	34
Есүсийн Үйлчлэлийн Оргил үе	36
Зөрчил	37
Дагалдагч байх нь	37
Ялалт	38

ГОЛ СЭДВҮҮД	39
Хуучин Гэрээний Өв.....	39
Эш таталт ба Зүйрлэл	39
Тэнгэрийн Хаанчлал	41
Мессиа Хаан	42
Үл Итгэгч Еврей Удирдагчид	43
Даруу ба Дөлгөөн Байдал.....	44
Бурханы Ард түмэн	45
Чуулган	46
Бурханы Гэр бүл.....	48
Дуудлага.....	50
ДҮГНЭЛТ.....	52
ХАМТРАГЧИД.....	53
ҮГСИЙН САН.....	55

Сайнмэдээний Номууд

Хоёрдугаар Хичээл

Матайн Сайнмэдээ

УДИРТГАЛ

1919 онд Бельгийн хаан Альберт галт тэргээр АНУ-ыг тойрон аялж байв. Тэрээр зүтгүүрийн талаар хангалттай мэдлэгтэй байсан тул арван милийн зайд инженер шиг хувцаслаад, галт тэргийг жолоодов. Дараагийн зогсоол дээр Альберт хааныг талархан угтахаар хүмүүс хайсан боловч олсонгүй. Тэд хаан хүний харагдах байдал, үйлдэл нь нэг тийм л байх ёстой доо гэсэн тогтсон хүлээцтэй байлаа. Тиймээс тэд төмөр каск, хөвөн даавуун цамц өмссөн өндөр эрийг Бельгийн хаан гэж үнэндээ бодсонгүй.

Нэг талаасаа Матайн Сайнмэдээний ном үүнтэй ижил түүхийг өгүүлдэг. Энэ бол нэг хааны түүх, тодруулбал Есүс хэмээх Иудейчүүдийн Хааны түүх юм. Гэвч тухайн үеийн олон хүн Түүнийг таниагүй. Яагаад гэвэл Тэр хүмүүсийн төсөөлж байсан шиг харагдаагүй, мөн тэдний хүлээж байсан шиг үйлдэл хийгээгүй. Тэр бол өөр төрлийн хаан байв.

Энэ бол бидний *Сайнмэдээний Номууд* цувралын хоёр дахь хичээл юм. Анхны Сайнмэдээний ном болох Матай номд анхаарлаа хандуулах тул бид энэ хичээлийг “Матайн Сайнмэдээ” гэж нэрлэсэн.

Матайн Сайнмэдээний талаарх бидний судлал гурван хэсэгт хуваагдана. Эхлээд бид Матай ном бичигдсэн түүхэн нөхцөл байдлын талаар авч үзэх болно. Хоёрдугаарт, бид бүтэц ба агуулгыг нь судлах болно. Гуравдугаарт, бид Матайн Сайнмэдээний зарим гол сэдвүүдийг авч үзэх болно. Ингээд Матайн Сайнмэдээний бичигдсэн түүхэн нөхцөл байдлын талаар эхлээд авч үзэцгээе.

ТҮҮХЭН НӨХЦӨЛ

“Яагаад би Библийн хам сэдэв буюу нөхцөл байдалтай нь холбоотой бүхнийг мэдэх хэрэгтэй вэ? Би монгол хэл дээр сайн орчуулсан Библийг уншаад, юу гэсэн утгатай болохыг ойлгочхож болохгүй гэж үү?” гэж олон хүмүүс асуудаг. Би хам сэдэвгүй текстийг өөрийн хүссэн зүйлээ илэрхийлэх шалтаг гэж хэлэх дуртай. Гол асуудал бол эртний бүх бичвэрүүд нь тодорхой төрлийн түүх, утга зохиол, уран илтгэл, археологи, шашны хам сэдвийн нөхцөлд өгөгдсөн бөгөөд эдгээр хам сэдвүүд нь биднийхээ бүгд ялгаатай байдаг. Өнгөрсөн үе бол өнөөдрөөс тэс өөр. Орчин үеийн бүх бодол таамгаараа өнгөрснөө унших гэдэг анахронизмын буюу цаг хугацааны ташаарлын эсрэг бидэнд байгаа хамгийн том хамгаалалт бол Библийг хам сэдвийнх нь хүрээнд сайтар судлах явдал юм.

— Др. Бен Витерингтон III

Библийн номуудыг нарийн тайлбарлахдаа бичээч нь хэн бэ, түүхэн хам сэдэв нь юу вэ гэх мэт тухайн цаг үеийн асуудлуудыг ойлгох нь чухал. Яагаад гэвэл бичээчид нь номоо бичихдээ тухайн уншигчид нь нэг л соёлд ажиллаж амьдарч байгааг урьдаас мэдэж таамаглаж байдаг. Мөн тэд өөрсдийнх нь хэлж буй зүйлсийг өргөн хүрээнд мэдэж байгаа гэж шууд боддог. Тиймээс бидний даалгавар бол ихэнх тохиолдолд энэхүү бичээч нь чухам хэн байсан бэ, түүний соёл нь ямар байсан бэ гэдгийг олж мэдэх явдал юм. Ингэснээр бид илүү өргөн соёл ба түүхэн нөхцөлөөс нь илүү их ухаарал авдаг. Тэгээд бид аливаа таамаглал ба тухайн бодит байдлыг тодорхой болгож чадна.

— Др. Жеймс М. Хэмилтон

Бид Матайн Сайнмэдээний номын түүхэн нөхцөл байдлыг гурван үе шаттайгаар авч үзэх болно. Эхлээд бид Матай уг бүтээлийн бичээч болох талаар ярих болно. Хоёрдугаарт, бид Матайн анхны хүлээн авагчид буюу уншигчдын тухай ярих болно. Гуравдугаарт, бид Матай номыг бичсэн шалтгаан эсвэл нөхцөл байдлуудыг тодорхойлон үзэх болно. Эхлээд уг Сайнмэдээний номын бичээч нь хэн болох талаар хариулт олж авцгаая.

Бичээч

Аливаа ном, захидал эсвэл өөр ямар нэг бичвэрийг судлахдаа үүнийг хэн бичсэнийг мэдэх нь бидэнд тун тустай байдаг. Эцсийн эцэст бид бичээч, түүний хам сэдвийн талаар ихийг мэдэх тусам түүний үзэл бодол, ач холбогдлыг нь ойлгоход илүү сайн бэлтгэгддэг. Энэ нь Библи судлахад ч мөн адил байна. Бид Библийн бичээчдийн талаар ихийг мэдэх тусам тэдний бидэнд зааж буй сургамжийг ойлгоход илүү сайн бэлтгэгддэг. Тиймээс бид Матайн Сайнмэдээний номыг судлахдаа бидний асуухыг хүсэж буй хамгийн эхний асуулт бол "Энэ номыг хэн бичсэн бэ?" гэдэг нь юм.

Бид *Матайн Сайнмэдээний номын* бичээчийг хоёр шаттайгаар судална. Эхлээд бид энэ номыг Есүсийн анхны арван хоёр дагалдагчийн нэг байсан элч Матай бичсэн гэх уламжлалт үзлийг батлах болно. Хоёрдугаарт, бид Матайн хувийн түүхийг судлах болно. Энэхүү Сайнмэдээний номыг Матай бичсэн гэсэн уламжлалт үзлээс эхэлцгээе.

Уламжлалт Үзэл

Өнөөдөр зарим эрдэмтэд үүнд эргэлзэж байгаа ч Матай буюу элч Матай нь үнэхээр Матайн Сайнмэдээний бичээч гэдэгт бид

итгэлтэй байж чадна гэж би бодож байна. Нэгдүгээрт, анхны чуулганы эцгүүд аливаа хуурамч зохиомол бичээсүүдийг онгод оруулагдсан бичвэрт хамааруулж баталгаатай, каноны бичээс гэж үзэхийг эрс эсэргүүцдэг байсныг бид мэднэ. Хоёрдугаарт, Матайг бичээч гэдэгтэй өрсөлдөх өөр уламжлал огт байхгүй. Бидэнд буй ганц уламжлал нь энэ номыг Матай өөрөө бичсэн гэдэг үзэл юм л даа. Гуравдугаарт, хэрэв анхны чуулган хэн нэгний нэрийг түүхийн шалтгаанаас өөр ямар нэгэн сэдлээр энэ Сайнмэдээний номтой холбох гэж байгаа бол ямар нэг нэр зохиох эсвэл элч нарын нэгийг заавал сонгох тохиолдолд Матай нь тун тааруухан сонголт болно. Яагаад гэвэл Матай нь татвар хураагч байсан. Тэрээр еврей хүмүүсийн хорсон зэвүүцдэг мэргэжилтэй нэгэн байв. Гэсэн хэдий ч Матайн Сайнмэдээний ном нь еврей уншигчдад Есүс бол Мессиа гэдгийг итгүүлэх зорилготой Сайнмэдээний ном. Тийм учраас еврейчүүдийг Есүс бол Мессиа гэдэгт итгүүлэхийн тулд энэхүү Сайнмэдээний номыг бичсэн мөртөө тэд энэ Сайнмэдээний номын бичээчээр Матайг сонгох байсан гэж үү? Энэ нь ямар ч итгэл төрүүлэхгүй байгаа биз. Тэд Матайн нэрийг Матайн Сайнмэдээний номтой холбосон цор ганц шалтгаан бол Матай үнэндээ үүнийг бичсэн гэдэгт итгэх хангалттай сайн шалтгаан байсан гэсэн үг юм.

— Др. Стивен Кован

Матай нь анхны Сайнмэдээний номыг бичсэн гэсэн уламжлалт үзэл нь чуулганы эхний зуунаас л гаралтай. Энэ Сайнмэдээний номын гарчигтай эртний гар бичмэл болгонд уг гарчиг нь Матайг л цохож, ганцхан Матай гэж бичигдсэн байдаг. Энэ Сайнмэдээний ном Матайн нэрийг дурдан холболгүйгээр чуулгануудын дунд гараас гарт дамжиж байсан гэх ямар нэг нотолгоо бидэнд байхгүй.

Анхны Сайнмэдээг Матайтай холбосон хамгийн эхний хүмүүсийн нэг бол Хераполисын Папиас байв. Папиас нь 1-р зууны сүүлчээс 2-р зууныг хүртэл амьдарч байжээ. Тэрээр чуулганы талаар мэдэж болох хамгийн эртний үзэл баримтлалыг бидэнд дэлгэдэг.



Еусебий

МЭ 325 оны орчим бичсэн чуулганы түүхч Кайсарын Еусебий Матайн Сайнмэдээний номын бичээчийн талаарх Папиасын гэрчлэлийг *Сүмийн Түүх* номын 3-р дэвтэр, 39-р бүлгийн, 16-р хэсэгт тэмдэглэжээ. Энд тэрээр:

“Матай нь логиа буюу Есүсийн талаарх үгсийг цэгцтэй дарааллаар байршуулав” гэжээ.

Эндээс бид хоёрдугаар зууны эхэнд Папиас уг Сайнмэдээний номыг Матайд хамааруулсныг харж болно. Матай анхны Сайнмэдээний номыг бичсэн гэсэн өөрийн үзлийг батлахын тулд Еусебий нь Папиасыг эш татсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

МЭ 180-аад онд бичиж байсан анхны чуулганы эцэг Лион хотын Иренаус мөн л анхны Сайнмэдээний номыг Матайтай холбосон. *Тэрсүүдийн эсрэг* номынхоо 3-р дэвтэр, 1-р бүлэг, 1-р хэсэгт тэрээр энэ тухай өгүүлсэн нь бий. Энд:

“Петр, Паул хоёр Ромд номлож, чуулганы суурийг тавьж байх хооронд Матай мөн Еврейчүүдийн дунд тэдний төрөлх хэллэгээр Сайнмэдээний номыг бичсэн” гэжээ.



Иренаус

Тертуллиан нь үүнээс арай хожуу буюу МЭ 155 - 230 оныг хүртэл амьдарч байв. Тэрээр *Марсионы эсрэг* номын 4-р дэвтрийн 2-р бүлэгт Матайг бичээч болохыг баталжээ. Энд:

“Тийм болохоор элч нарын дундаас Иохан, Матай хоёр эхлээд бидэнд итгэлийг суулгадаг... Лук, Марк хоёр дараа нь үүнийг маань сэргээдэг” гэжээ.



Тертуллиан

Иренаус, Тертуллиан хоёрын үзлээр Матай энэхүү Сайнмэдээний номыг бичсэн аж. Анхны чуулган ч уг үзлийг баримталдаг байв. Анхны Сайнмэдээний номыг Матайд хамааруулах нь баттай хүлээн зөвшөөрөгдсөн.

Матай бичсэн талаарх эдгээр анхны дүгнэлтүүд нь Матайн харьцангуй нэр хүнд багатай байдлаас болж илүү баттай болдог гэдгийг ойлгох нь мөн чухал юм. Хэрэв чуулган эсвэл хэн нэгэн Сайнмэдээний номыг өөрсдийн сонгосон элчтэй холбож, улам үнэмшилтэй болгохыг хүссэн бол тэд илүү алдартай дагалдагчдын нэгийг сонгох байсан биз. Харин Матай нь Сайнмэдээний номуудад тун ховор дурдагддаг. Энэ нь түүний нэрийг энэхүү Сайнмэдээний номд хуурамчаар хавсаргасан байх магадлалыг бууруулдаг.

Юуны өмнө бид нэгдүгээр зууны үеийн нүдэн гэрчийн мэдүүлгийн ач холбогдлыг хүлээн авах ёстой. Нүдэн гэрчүүдийн мэдүүлгийг маш өндөр үнэлдэг байсан бөгөөд нүдэн гэрчийн мэдүүлгийг хэн ч үл тоомсорлодоггүй байв. Энэ бол аливаа болсон үйл явдлын талаарх бараг л халдашгүй дархан баримт л гэсэн үг. 2-р зууны эхэнд Папиас Матайн Сайнмэдээний номыг элч Матай бичсэн гэж дурдсаныг бид бас мэднэ. Папиас өндөр насалсан учир элч нарыг шууд таньдаг байх их магадлалтай. Хэдий Матайн Сайнмэдээнд Матайг бичээч нь гэж дурддаггүй ч үнэндээ түүнийг бичсэн гэдэгт итгэлтэй байх шалтгаан бий. Энэ нь хамгийн эртний Матай номын хуулбаруудад бичвэрийн эрх мэдэл ба бичээч нь Матай юм гэдгийг тэмдэглээгүй тохиолдол гэж байгаагүй явдал юм.


— Пастор Майкл Ж. Глодо

Мэдээжийн хэрэг, орчин үеийн зарим шүүмжлэгч эрдэмтэд Библийн бичээчийн талаарх бусад олон уламжлалт үзэлд эргэлздэг шигээ элч Матай анхны Сайнмэдээний номыг бичсэн гэдэгт эргэлзсээр ирсэн. Гэвч Матайг бичсэн гэх эртний хүчтэй баталгаанууд хийгээд өөр эртний үзэл санаа байгаагүй гэдэг нь түүнийг бичээч нь мөн гэж үзэх баттай үндсэн болдог.

Матай энэхүү анхны Сайнмэдээний номыг бичсэн гэсэн уламжлалт үзлийг судалсан тул одоо бид Матайн амьдралын түүхийг авч үзэцгээе.

Хувийн Амьдралын Түүх

Матайн хувийн амьдралын түүхийн талаар хэд хэдэн чухал баримтыг Бичвэр бидэнд өгүүлдэг. Тухайлбал, түүнийг Иудей бас татвар хураагч байсан гэж дурдсан байдаг. Матай нь Иудей хүн байсан гэсэн баримтаас эхлээд бид уг хоёр зүйлийг хоёуланг нь нарийвчилж үзэх болно.



Матайн Иудейн уг гарлыг хэд хэдэн байдлаар тодорхой өгүүлсэн байдаг. Юуны өмнө тэрээр Есүсийн арван хоёр дагалдагчийн нэг байсан бөгөөд тэд бүгд Иудей хүмүүс байв. Өөр нэг зүйл нь Матай өөрөө Иудей нэртэй байлаа. Матай гэх нэр нь өөрөө Еврей Хуучин Гэрээнээс гаралтай, Иудей нэр юм. Түүний өөр нэр болох Леви нь Марк 2:14, Лук 5:28 зэрэг эшлэлүүдэд Израилын нэг овгийн нэр байдаг. Тиймээс хоёр нэр хоёулаа Матайг Иудейн хүн байсан гэдгийг харуулж байна. Түүний еврей хэл дээр бичсэн эртний Христитгэлт тэмдэглэлүүд түүнийг Иудей гэдгийг харуулдаг талтай.

Матайн Иудей гарал нь түүний Сайнмэдээний номыг ойлгоход тун чухал суурь болдог. Учир нь энэ нь Иудейн тодорхой онцлогуудыг тайлбарлахад бидэнд тусалдаг. Бид энэ хичээлд уг Сайнмэдээний номын Иудей шинж чанарыг илүү нарийвчлан судлах болно. Одоохондоо дүрслэл болгон ганцхан жишээг дурдъя.

Матай 15:24 дээр Есүс дараах зүйлсийг тунхагласан болохыг Матай тэмдэглэсэн. Энд:

“—Би зөвхөн Израилын гэрийн алдагдсан хоньд руу илгээгдсэн юм”
гэсэн байдаг (Матай 15:24).

Матай нь Есүсийг Израилын ард түмний төлөө ирсэн гэдгийг бусад Сайнмэдээний номоос харьцангуй илүү олонтоо онцолсон байдаг.

Матайн Иудей гарал угсаанаас гадна түүний талаарх бас нэн зүйл бол тэрээр татвар хураагч байсан явдал юм. Нэгдүгээр зуунд Палестин дахь олон Иудейчүүд Ромын эзэнт гүрний нэрийн өмнөөс татвар хураадаг байжээ. Эдгээр татвар хураагчдын зарим нь нэг газраас нөгөө рүү тээвэрлэсэн барааны татварыг авдаг байв. Тэд татвар хураах эрхийг захирагчдаас худалдаад авчихсан хувийн бизнес эрхлэгчид

байсан гэж хэлж болно. Тэд татварын ханшийг хөөрөгдүүлэн нэмэх замаар ашиг хонжоо олдог байлаа. Үүний үр дүнд эдгээр татвар хураагчдыг дээрэмчин, хулгайч гэж үздэг байсан бөгөөд ийнхүү үзэх нь ч зөв зүйтэй байв.

Энэ шалтгааны улмаас еврей татвар хураагчид нутаг нэгтнүүдийнхээ өмнө давхар давхар буруутгагддаг аж. Нэгдүгээрт, тэд хүмүүсийн үзэн яддаг Ромын эзлэн түрэмгийлэгч хүчний төлөөлөгчид байв. Хоёрдугаарт, хувийн ашиг сонирхлынхоо төлөө өөрсдийн ард түмнээ мөлжин дээрэмдсэн. Үнэн хэрэгтээ тэднийг хорон, итгэх аргагүй хүмүүс гэж үздэг байсан тул эртний рабби нарын бичвэрүүдэд Иудейн шүүхэд мэдүүлэг өгөхийг нь ч хориглосон байлаа. Түүгээр ч барахгүй татвар хураагчдад худал хэлэх нь зөвтгөгдөх төдийгүй сайн зөвт эсэргүүцэл үзүүлээ гэж магтдаг байжээ.

Матай 9:9-10 дээр Есүс өөрийг нь дуудсан талаар Матай бичсэн байдаг. Тэрээр энд:

“Есүс тэндээс гарч явангаа, татварын газар суух Матай гэгч хүнийг харав. Тэр түүнд —Намайг дага гэсэнд тэр босож, Түүнийг дагалаа. Есүсийг айлд ширээнд тухлан байтал, татвар хураагчид, нүгэлтнүүд олноороо ирж, Есүс ба шавь нарынх нь хамт тухлан суув” гэжээ (Матай 9:9-10).

Матай өөрийгөө маш илэн далангүй дүрсэлсэн бөгөөд Есүсийн үед бусад татвар хураагчид хийгээд өөрийг нь “гэмтнүүд” гэж ангилдаг байсныг шууд хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр Матай өөрийгөө, Есүсийг болон өөрийн бичсэн Сайнмэдээний номыг Иудейчүүдийн удирдлагатай зөрчилдөх байранд аваачсан. Энэ зөрчлийг Матайн Сайнмэдээний номд байнга илэрхийлж байв. Жишээлбэл, Матай 21:31-32 дээр Есүс Иудейчүүдийн удирдлагыг хэрхэн шүүмжилснийг харцгаая. Тэрээр энд:

“—Үнэнээр Би та нарт хэлье. Татвар хураагчид ба янхнууд та нараас урьтаж Бурханы хаанчлалд орно. Учир нь Иохан зөвт байдлын замаар та нар дээр ирсэнд та нар түүнд итгээгүй. Харин татвар хураагчид ба янхнууд түүнд итгэсэн юм. Та нар үүнийг үзээд гэмшсэнгүй, дараа нь ч түүнд итгэсэнгүй” гэжээ (Матай 21:31-32).

Матай өөрийн гэмт амьдралынхаа түүхийг нээлттэй дэлгэх хүсэлтэй байгаа нь түүний Сайнмэдээний номын өөр нэг онцлог юм. Энэ талаар бид хичээлийнхээ сүүлд илүү нарийвчлан авч үзэх болно. Матай Есүс бол дагалдагчдадаа даруу байхыг уриалсан даруу Хаан гэдгийг бусад Сайнмэдээний номын бичээчдээс илүү их онцолсон байдаг. Өнгөрсөн амьдралаа бодитой хүлээн зөвшөөрснөөр нигүүлслийн хэрэгцээгээ чөлөөтэй илэрхийлж, өөрийг нь дуудаж, өөрчилсөн Хааныг дагахад бэлэн байгаагаа Матай зарлан тунхагласан. Есүс түүнийг Херодод үйлчилдэг гэмт зарцаас тэнгэрийн хаанчлалын Сайнмэдээний даруу үйлчлэгч болгон өөрчилсөн юм.

Даруу төлөв байдал нь бусад болоод бидэнд сайн зүйлс тохиолдоход баярлаж, сэтгэл хангалуун байгаа гэж харагдах ёстой байдаг. Гэвч энэ нь бусад хүмүүс ахиж дэвшиж, ямар нэг байдлаар

нэр хүндтэй байх эсвэл тэдний үйлс нь үр жимстэй харагдахад бид үүнд баяртай байх гэсэн үг байдаг. Бид үүний төлөө Бурханд талархаж, юуны түрүүнд Бурханыг хүндэлж, талархахыг эрхэмлэнэ. Бид зөвхөн өөрсдийнхөө төлөө бус, юу юунаас илүү Бурханы төлөө амьдрахыг л хүсдэг. Тиймээс, даруу байдал гэдэг нь миний ашиг сонирхол биелэхийг харах биш, харин өөр хүнээр дамжуулан эсвэл надаар дамжуулан Бурханы хүсэл биелэхийг эрэн хайх явдал юм.

— Др. Жон Э. Маккинли

Бид Матай анхны Сайнмэдээний номыг бичсэн гэсэн уламжлалт үзэл зөв хэмээн дүгнэж, түүний хувийн амьдралын түүхтэй бага зэрэг танилцлаа. Одоо харин бид Матайн бичсэн анхны хүлээн авагчид хэн болохыг судлах болно.

АНХНЫ ХҮЛЭЭН АВАГЧИД

Матай өөрийн анхны хүлээн авагчдыг тусгайлан танилцуулаагүй. Гэхдээ тэр бидэнд тэдний хэн болох талаар цөөн шижим өгчээ. Бидний харж байгаагаар Матай голчлон еврей Христитгэгчдэд зориулж бичсэн бололтой харагддаг.

Өмнөх хичээл дээр дурдсанчлан, бүх Сайнмэдээний номыг Христитгэгч уншигчдад зориулж тусгайлан бичсэн. Гэхдээ Матайн Сайнмэдээний номын хэд хэдэн онцлог нь үүнийг Иудей гаралтай Христитгэгч уншигчдад илүү хандаж бичсэн гэдгийг харуулдаг. Жишээлбэл, Матай бусад Сайнмэдээний номын бичээчдээс илүү Хуучин Гэрээнээс эш татсан байдаг. Есүс Хуучин Гэрээний хүлээлтүүдийг биелүүлсэн арга замуудыг тэрээр байнга онцолдог байв. Мөн Есүс бол иудейчүүдийн олон зууны турш хүлээж байсан Мессиа Хаан гэдгийг тэрээр онцгойлон тусгасан. Тэрээр Иудейчүүдийн асуудлыг онцолсон нь Есүсийн үл итгэгч Иудей удирдагчидтай хийсэн зөрчилдөөн дээр ч харагддаг. Үүнийг Матай бусад Сайнмэдээний номын бичээчдээс илүү дэлгэрэнгүй дүрсэлсэн байдаг. Мөн Матай Есүсийн Хуучин Гэрээний хуультай харилцах харилцаанд, ялангуяа Есүс хуулийн Эзэн гэдэгт их төвлөрсөн байдаг.

Уг хичээлээрээ бид эдгээр онцлогуудаас заримыг илүү дэлгэрэнгүй авч үзэх болно. Тиймээс харин энэ хэсэгт бид Матай нь Иудей уншигчдад хандан бичсэн гэдгийг илэрхийлэх хоёр жишээг дурдах болно. Эхнийх нь "тэнгэрийн хаанчлал" гэсэн хэллэгийг Матай хэрэглэсэн явдал юм.

Тэнгэрийн Хаанчлал

Өмнөх хичээлд бид Сайнмэдээний дөрвөн ном бүгд Бурханы хаанчлалын сэдвээр нэгдмэл байдгийг тэмдэглэсэн. Гэвч Матай "Бурханы хаанчлал" гэсэн хэллэгийг бараг ашигладаггүй. Үүний оронд тэрээр "тэнгэрийн хаанчлал" гэсэн хэллэгийг ихэвчлэн ашигладаг байсан. Матайн Сайнмэдээний ном бол Библид ийм

нэр томьёог ашигласан цорын ганц ном юм. Бидний харж байгаачлан уг хоёр хэллэг нь ижил утгатай.

Иудейчүүд Бурханыг ихэд хүндэлдэг тул нэрийг нь эсвэл түүнийг илэрхийлэх ямар нэг зүйлийг шууд нэрлэж ашиглахаас зайлсхийдэг. Тийнхүү тэд Бурханы нэрийг санамсаргүйгээр дэмий хоосон дуудахгүй байж чаддаг байв. Ингэхдээ тэд үүнийгээ илэрхийлсэн нэг арга бол "Бурхан" гэдэг үгийг "тэнгэр" гэсэн үгээр сольсон явдал юм. Матай "тэнгэрийн хаанчлал" гэсэн хэллэгийг ашиглахдаа яг л ийнхүү бодож хэрэглэсэн. Синоптик Сайнмэдээний номуудын зэрэгцээ багцлалуудыг харьцуулах үед бусад Сайнмэдээний бичээчид "Бурханы хаанчлал" гэсэн нэр томьёог ашигласан газарт Матай "тэнгэрийн хаанчлал" гэсэн хэллэгийг ашигласан болохыг бид харж болно.

Бусад Сайнмэдээний номд бид "Бурханы хаанчлал" гэж дурдах хэрэгцээтэй бүх газарт л Матай "тэнгэрийн хаанчлал" гэдэг хэллэгийг ашигласан. Матай "Бурханы хаанчлал" гэсэн хэллэгийг хэд хэдэн газар ашигласан байдаг. Учир нь Матай өөрөө Иудей бичээч төдийгүй Иудей Христитгэгч байсан юм. Мөн Иудейчүүдийн хувьд Бурханы нэрийг ашиглахад хэтэрхий ариун дагшин байлаа. Тиймээс Бурхан гэж илэрхийлэх өөр нэг арга зам бол "тэнгэр" гэсэн хэллэгийг ашиглах явдал байв. Өөр Сайнмэдээнд “Би тэнгэр ба газрын эсрэг нүгэл үйлдсэн” гэж бид уншдаг. Энэ нь "Би Бурханы эсрэг нүгэл үйлдсэн" гэсэн утгатай. Нэг аюул нь юу вэ гэхээр бид "тэнгэрийн хаанчлал" гэсэн хэллэгийг сонсохдоо үүнийг буруу сонсоод, "Өө, энэ нь үнэхээр ер бусын, хийсвэр сонсогдож байна... тэнгэрийн хаанчлал гэдгийг харж чадахгүй шүү дээ" гэж хэлж мэдэх юм. Гэвч үнэн хэрэгтээ тэрээр Бурханы хаанчлалын тухай ярихдаа Бурхан үнэхээр Есүс Христээр дамжуулан одоо энэ дэлхийн Хаан болж байна гэсэн санаагаар хэлсэн юм. Тиймээс Христитгэгчид хожим нь “тэнгэрийн хаанчлал”-ыг буруугаар ойлгох аюул үнэхээр бий юм. Үнэндээ Есүс "Бурхан бол Хаан бөгөөд Надаар дамжуулан Хаан болж байна" хэмээн хэлж байв.

— Др. Петр Уолкер

Марк 4:30-31 дээр гичний үрийн тухай сургаалт зүйрлэлийг Марк хэрхэн дүрсэлснийг сонсоцгооё. Энд:

“[Тэр]: —Бурханы хаанчлалыг бид юутай зүйрлүүлэх вэ? Эсвэл ямар сургаалт зүйрлэлээр илэрхийлэх вэ? Энэ нь хөрсөнд суулгах үед газар дээрх ямар ч үрээс жижиг байдаг гичний үр адил юм” гэжээ (Марк 4:30-31).

Энд Марк ердийн хэллэг болох Бурханы хаанчлал гэдэг үгийг ашигласан байна. Харин Матай 13:31 эшлэл дээрх сургаалт зүйрлэлд Матай үүнийг юу гэснийг харцгаая. Тэрээр энд:

“Есүс тэдэнд өөр нэгэн сургаалт зүйрлэл хэлэхдээ —Тэнгэрийн хаанчлал нь хүний авч, цэцэрлэгтээ суулгасан гичний үр мэт юм” гэсэн (Матай 13:31).

Матай энэ үйл явдлыг дурдахдаа Маркийн "Бурханы хаанчлал" гэсэн нэр томьёог ашигласан хэсэгт "тэнгэрийн хаанчлал" гэсэн нэр томьёог хэрэглэжээ.

Матай дээр тэнгэрийн хаанчлал гэснийг Марк болон Лук ном дээрх Бурханы хаанчлал гэсэн ижил хэсгүүдтэй харьцуулан харвал тэд нэг л утга санаа, нэг л зүйлийн тухай өгүүлж буй нь илэрхий байдаг. Тэгэхлээр та Матайг бүхэлд нь уншвал тэнгэрийн Бурханыг газар дээрх хүмүүнтэй харьцуулж буй гол сэдвийг олж харах болно. Нэг талд Тэнгэрийн хаанчлал гэж нэрлэдэг Бурханы хаанчлалын арга зам, нөгөө талд дэлхийн хаанчлалууд гэгддэг хүн төрөлхтний засаглаж, ноёрхож, бие биедээ хандаж буй арга зам байна. Матайн хувьд тэнгэрийн хаанчлалын тухай ярих нь хаанчилж, захирч, дахин ирэхээ амлаж буй бидний тэнгэр дэх Эцэг болон зөвхөн энэ дэлхийн зүйлсийн хооронд буй ялгааг мэдрүүлэх маш хүчтэй арга зам байлаа. Тиймээс Матайн хэлж буй тэнгэрийн хаанчлал гэдгийн утга учир бол ирчхээд буй Бурханы хаанчлал ба энэ дэлхийн бүх хаанчлал, засаглалын хоорондын ялгааг бидэнд мэдрүүлж, амтлуулах явдал юм шүү дээ. Энэ хоёр бодит байдлын хооронд ялгаа бий. Матай ийнхүү "тэнгэрийн хаанчлал"-ын тухай өгүүлснээрээ Бурханы хаанчлал бүрэн биелэх тэр цаг мөчийг амсаж мэдрэх боломжийг бидэнд олгодог.

— Др. Жонатан Т. Пеннингтон

Матай Есүсийн Иудейчүүдтэй хэрхэн ярьдаг байсныг байгаагаар нь булгасан бол Марк болон Шинэ Гэрээний бусад бичээчид үүнийг илүү олон хүмүүст ойлгомжтой болгохын тулд "Бурханы хаанчлал" гэсэн хэллэгийг ашигласан гэж олон эрдэмтэд үздэг. Гэхдээ энэ нь үнэн эсэхээс үл хамааран Матай "тэнгэрийн хаанчлал" гэсэн хэллэгийг ашигласан нь түүний анхны хүлээн авагчдыг Иудей хүмүүс байсныг баттай болгодог.

Иудейн Ёс Заншлууд

Матайн Сайнмэдээний хүлээн авагчид нь Иудей хүмүүс байсан гэдгийг харуулдаг нэг тал бол Матай өөрийн хүлээн авагчдыг Иудейн зан заншлын талаар хангалттай мэдлэгтэй гэж үзсэнд байдаг. Зөвхөн нэг жишээ дурдахад Матай 15:1-2 дээр Матай энэ талаар ийнхүү тэмдэглэжээ. Энд:

“Тэгтэл Йерусалимаас фарисайчууд ба хуулийн багш нар Есүс дээр

ирж —Таны шавь нар яагаад ахмадын ёс заншлыг зөрчинө вэ? Тэд талх идэхдээ гараа угаахгүй юм” гэсэн байна (Матай 15:1-2).

Марк үүнтэй ижил түүхийг Сайнмэдээнийхээ 7:1-5-р эшлэлд оруулсан байдаг. Гэхдээ Марк Иудейчүүдийн гар угаах заншлын тухай гурван эшлэлээр дэлгэрүүлэн тайлбарласан бөгөөд ингэснээр Ромын хүлээн авагчдад уг заншлыг ойлгоход тусалжээ. Харин Матай хүлээн авагчдадаа зориулж ийм тайлбар нэмэх шаардлагагүй гэж үзэв.

Одоо Матайг Иудей хүлээн авагчдад зориулж бичсэн гэж үзэхэд тохирохгүй гэж харагддаг нэг чанар түүний Сайнмэдээнд бий. Хэд хэдэн тохиолдолд Матай Есүсийн арамей хэлээр ярьж байгааг эш татсан бөгөөд дараа нь тэдгээр арамей үгсийг хүлээн авагчдынхаа хэл рүү орчуулсан байдаг. Жишээлбэл, Матай 27:46 эшлэлд байдаг үгсийг сонсоцгооё. Энд:

“Есүс чанга дуугаар *"Ели, Ели, лема сабахтани?"* Энэ нь "Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?" гэсэн байна (Матай 27:46).

Хүлээн авагчид нь үндсэндээ Иудей хүмүүс байсан ч Матай яагаад ингэж бичсэн байж болох талаар олон янзын тайлбар байдаг. Нэгдүгээрт, түүний хүлээн авагчид голчлон иудейчүүд байсан ч зөвхөн тэднээр зогссонгүй. Тиймээс уншигчдынх нь дунд байсан Иудей бус хүмүүст ч мөн зориулж эдгээр орчуулгуудыг оруулсан байж болох юм. Хоёрдугаарт, Матайн хүлээн авагчид дунд Палестинаас гадна амьдардаг, арамей хэл мэдэхгүй хүмүүс байсан байж магадгүй. Гуравдугаарт, Матай зүгээр л өөр эх сурвалжаас мэдээллийг хуулсан байж болох юм. Жишээлбэл, Матай 27:46-р эшлэлийн орчуулгууд нь Марк 15:34 эшлэлд мөн гардаг бөгөөд Матай үүнийг эх сурвалж болгон ашигласан байж мэдэх юм.

Энэ бүх үйл явдлуудад Иудей Христитгэгчдийн Есүст итгэх итгэлийг нь бэхжүүлэхийн тулд тэдэнд онцгой чухал байсан олон асуудлыг хөндөн бичсэн харагддаг. Тиймээс энэ нь иудейчүүдэд зориулсан гэсэн хүчтэй нотолгоо болдог.

Анхны Сайнмэдээний бичээч болон хүлээн авагчдыг судалсан тул одоо бид түүний бичих болсон үндсэн шалтгааныг судлахад бэлэн боллоо.

ҮНДСЭН ШАЛТГААН

Номыг бичих болсон "үндсэн шалтгааны" тухай ярихад түүхэн хам сэдэвтэй нь холбоотой хэд хэдэн зүйлийг авч үздэг. Үүнд уг номын бичигдсэн огноо, байршил, зорьж буй хүлээн авагчдынх нь байршил болоод бичигдэх болсон зорилго гэх зэрэг нь ордог. Номыг хэзээ, хаана, хэнд, яагаад бичсэнийг мэдэх нь түүний хам сэдэв буюу нөхцөл байдлынх нь талаар маш их мэдээллийг бидэнд өгдөг. Энэ нь түүхэн нөхцөл, хэлзүйн дүрэм болон үгсийн сан, шашны ба нийгмийн таамаглалууд, бичээч ба уншигчдын хоорондын харилцаж буй арга замыг ойлгоход бидэнд тусална. Мөн эргээд энэ мэдээлэл бидэнд номыг ойлгож, хэрэгжүүлэхэд тусалдаг.

Бид Матайн Сайнмэдээг бичих болсон үндсэн шалтгааны гурван талыг авч үзэх болно. Нэгдүгээрт, бичигдсэн огноо, хоёрдугаарт, бичээч болон хүлээн авагчдынх нь байршил, гуравдугаарт, бичсэн зорилго. Матайн Сайнмэдээний

огнооноос эхэлцгээе.

Огноо

Нэгдүгээрт, ихэнх эрдэмтдийн үзэж байгаагаар Матай нь Маркийн Сайнмэдээг эх сурвалжаа болгон ашигласан байх магадлалтай. Бид дараагийн хичээл дээр үзэх юм. Ямартай ч Марк нь МЭ 64 оны орчим бичигдсэн байх магадлалтай байдаг. Хэрэв энэ нь зөв бол Матай нь хамгийн эртдээ 60-аад оны дундаас сүүл хүртэлх он хооронд бичигдсэн байж болох талтай.

Хоёрдугаарт, Матай нь Есүсийн элч байсан. Энэ нь Есүстэй хамт үйлчилж байх үедээ буюу МЭ 30 он гэхэд тэрээр аль хэдийн насанд хүрсэн байсан гэсэн үг юм. Тиймээс хэрэв Матай гайхалтай урт наслаагүй л бол түүний бичиж болох хамгийн сүүлийн огноо нь I зууны төгсгөл орчимд байсан болж таарна.

Энэ нь Матай бичсэн байж болох хангалттай өргөн хүрээг бидэнд өгдөг. Гэхдээ бид Матайн бичсэн зүйлсийг нарийн анзаарвал энэ хүрээн дотор огноог нь улам тодорхой болгож чадна. Тодруулбал, Матай сүм, түүнчлэн үүнтэй нягт холбоотой байсан Садукайчуудын тухай байнга дурддаг байв. Эдгээр эшлэлийн зарим нь ихэвчлэн түүхэн шинжтэй боловч цөөн хэдэн эшлэлээс үзэхэд Матайг бичиж байх цаг үед сүм болон Садукайчууд хоёулаа чухал хүчин зүйлс байсан нь харагдана. Сүм нэгэнт МЭ 70 онд устгагдсан тул Матай үүнээс өмнө нь бичсэн байж гэмээнэ энэ нь хамгийн их утга учиртай болно.



Матай Сайнмэдээгээ
магадгүй МЭ 67
эсвэл 68 оны үед
бичсэн гэж

Эдгээр бүх нотлох баримтуудаас харвал Матай Сайнмэдээгээ 60-70 оны сүүлчээр, магадгүй МЭ 67 эсвэл 68 оны үед бичсэн гэж дүгнэх нь зүйтэй болов уу. Мэдээж үүнд төгс итгэлтэй байх боломжгүй. Гэвч аз болоход Матай бичсэн огноог ойролцоогоор мэдэх нь тустай ч энэ нь түүний сургаалыг тайлбарлахад нэн чухал ач холбогдолгүй байдаг.

Ингээд бид энэхүү Сайнмэдээний бичигдсэн огноог харсан болохоор бичээч болон хүлээн авагчдын газарзүйн байршлын талаарх асуулт руу орцгооё.

Байршил

Эрдэмтэд энэхүү Сайнмэдээний номын байршлын талаар маргасаар ирсэн байдаг. Тиймээс бид дүгнэлт хийхдээ ягшмал байж болохгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч хэд хэдэн нарийн ширийн зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

Юуны түрүүнд Матай голчлон Иудей Христитгэгчдэд зориулж бичсэн учраас тэрээр Сайнмэдээгээ иудейн хүн ам голчлон амьдардаг газарт хаягласан байх магадлалтай. Палестин бол Иудейчүүдийн уламжлан амьдарсаар ирсэн нутаг байсан, мөн тэд тэнд төвлөрөн суурьшсан байсан тул байж болох хамгийн өндөр магадлалтай нь юм.

Гэхдээ мөн Сирийн зарим хэсэгт хангалттай их Иудейчүүд амьдарч байв.

Сири дэх Антиохын бишоп байсан Игнатиус бол Матайн Сайнмэдээг мэддэг гэдгээ харуулсан Чуулганы Эцгүүдийн хамгийн эртнийх нь юм. Энэ шалтгааны улмаас Матай Сирийн Антиох дахь итгэгчдэд хандан бичсэн гэж олон эрдэмтэд үздэг. Мэдээж хэрэг Матай Газар дундын тэнгис орчмын бүх Иудей Христитгэгчдэд хандан захидлыг илүү өргөн хүрээний хүлээн авагчдад бичсэн байхыг үгүйсгэхгүй. Палестин, Сири эсвэл Ромын эзэнт гүрний доторх Иудейн хүн ам ихтэй бусад газрууд ч Матайн иудейн шинжийг агуулсан уг хүчирхэг Сайнмэдээг түгээхэд тохиромжтой газар байх боломжтой.

МЭ 1-р зууны үед Иудейчүүд Ромын эзэнт гүрний ихэнх хэсэгт, цаашлаад дорно зүгт өргөн тархсан байв. Энэ нь урт хугацааны түүхийн туршид болсон явдал. Вавилоны цөллөгөөс хойш Иудейчүүд Палестины газар нутгийн гадна амьдарсаар ирсэн. Тэд урьд амьдарч байснаараа Алс Дорнодод үргэлжлүүлэн амьдарсаар байлаа. Энэ нь орчин үеийн Ирак буюу Месопотамид байв. Дараа нь тэд Сири, Дамаск руу ирж, түүнээс хойш Диаспора буюу тархан суурьшсан иудейчүүд гэсэн нэрэнд тохирсон байдлаар баруун тийш Бага Ази буюу орчин үеийн Турк, мөн Ром буюу Ромын Тибер голын эрэг дээр амьдарч байсан. Мөн Хойд Африкд ч иудейн хүн ам байсныг мартаж болохгүй. Бид Хойд Африкаас Иерусалим руу ирсэн Курений Симоны тухай Сайнмэдээний номуудаас уншдаг. Тиймээс, Ромын эзэнт гүрний зүүн хагасыг бүхэлд нь, бүр түүнээс зүүн тийш ч иудейчүүд амьдарч байсан гээд төсөөлөөд үз дээ.

— Др. Питер Уолкер

Ингээд бид Матайн Сайнмэдээний огноо, байршлын талаар ярилцлаа. Харин одоо бид Матайн Сайнмэдээг бичсэн зорилгыг авч үзэж болно.


Зорилго

Ерөнхийд нь хэлбэл, Есүс хэн байсан, Түүний юу хийсэн тухай үнэн түүх үнэхээр чухал байсан тул Матай үүнийг бичжээ. Гэхдээ түүнд илүү тодорхой, илүү ойрын зорилгууд байсан. Тодруулбал, Матай иудей Христитгэгчдийн Есүсийг мессиа Хаан гэж итгэх итгэлийг нь бэхжүүлэхийн тулд тэдэнд захидал бичсэн.

Матай бичиж байх үед Христитгэгчид болсон иудейчүүдийг иудейн эрх баригчид нь, мөн ихэнхдээ хуучин найз нөхөд, гэр бүлийн гишүүд нь эрс эсэргүүцэн зовоож байв. Тухайн үеийн Газар дундын тэнгисийн ертөнцөд хавчлагад өртөх нь Иудей Христитгэгчдийн амьдралын салшгүй хэв маяг болж байсныг Үйлс номонд тодорхой бичсэн байдаг. Үйлс 8:1 дээр энэ тухай өгүүлдэг. Энд:

“Тэр өдөр Йерусалим дахь чуулганы эсрэг хүчтэй хавчлага өрнөв. Элч нараас бусад нь бүгд Иудей ба Самарийн нутгуудаар тархав” гэжээ (Үйлс 8:1).

Хавчлагын улмаас Есүсийг Мессиа болгон дагасан иудейчүүд өмнөх амьдралдаа эргэн орж, Христитгэлийг орхих сорилттой тулгарч байсан нь гарцаагүй. Энэхүү сорилтын хариуд Матай Есүс бол тэнгэрийн хаанчлалыг авчирсан жинхэнэ Мессиа гэдгийг тэдэнд сануулахын тулд бичжээ. Түүний Сайнмэдээ бол урам зоригийн түүх, тайтгарлын түүх юм. Гэвч энэ нь бас сорилтын түүх байсан юм. Яагаад гэвэл Есүс тэдний олонхынх нь хүсэн хүлээж байсан арга замаар хаанчлалыг авчраагүй бөгөөд хаанчлалын шаардлага нь дэндүү их байлаа.



Есүс хаанчлалыг гурван үе шаттайгаар авчирсан.

Энэ хам сэдэв дотор мессиагийн хаанчлалын талаарх Хуучин Гэрээний хүлээлтийг Есүс биелүүлчихсэн гэдгийг Матай уншигчдадаа баттай болгосон юм. Үүний зэрэгцээ тэнгэрийн хаанчлал хараахан бүрэн гүйцэд болоогүй байв. Тиймээс Матай мөн Хаан Өөрөө эргэн ирж, бүх зүйлийг зөв болгох хүртэл үнэнч хэвээр байхад Иудей итгэгчдийг урамшуулан дэмжих зорилгоор бичжээ. Өөрөөр хэлбэл Есүс хаанчлалынхаа дайснуудыг устгаж, үнэнч хүмүүсээ хаанчлалынхаа ерөөлүүдэд бүрэн дүүрэн оруулах хүртэл гэсэн үг юм.

Тийм ч учраас Матай тэнгэрийн хаанчлалын сэдвийг байнга л дурдсан байдаг. Үнэндээ тэрээр Сайнмэдээндээ “хаан”, “хаанчлал” гэсэн үгсийг 75 орчим удаа ашигласан. Сайнмэдээний бусад гурван бичээч хамтдаа нийлээд эдгээрийг 110-аас илүүгүй удаа ашиглажээ. Матайн хувьд иудейн хүлээн авагчдаа урамшуулж, уриалах хамгийн шилдэг арга бол мессиа Хаан болон Түүний хаанчлалын түүхийг өгүүлэх явдал байв.

Матайн Сайнмэдээнд тэнгэрийн хаанчлалын талаар шаргуу онцолсон байгааг бид харж болно. Матай Сайнмэдээгээ Есүсийг Давид хааны хууль ёсны өв залгамжлагч гэдгийг харуулах зорилгоор Түүний ургийн бичгийг танилцуулж эхэлсэн байдаг. Давидын удмын энэ хаан бол Назарын Есүс мөн. Түүний уншигчид нь буюу түүний жинхэнэ хүлээн авагчид нь үндсэндээ иудей хүмүүс байсан гэж бид итгэдэг. Тиймээс энэ ном нь тэдгээр

хүмүүст "таны жинхэнэ хаан чинь Тэр шүү дээ" гэдгийг харуулахыг зорьсон. Тэрээр Сайнмэдээндээ "тэнгэрийн хаанчлал"-ыг тодорхойлохдоо Христийн засаглал нь бүх хүмүүс хийгээд тэнгэр огторгуйг ч захирч байгаа хэмээн дүрсэлсэн. Ингэснээрээ тэрээр тэнгэрийн хаанчлалын бодит илэрхийллийг онцолсон юм. Энэ бол эрх мэдлийн асуудал. Фарисайчууд болон садукайчууд Есүсээс "Чи ямар эрх мэдлээр эдгээрийг үйлддэг вэ?" хэмээн үргэлж асуусан байдаг. Сайнмэдээ нь Есүсийн "Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн" гэсэн үгээр төгсдөг шүү дээ. Хаанчлалын энэхүү санаа нь хүмүүсийн хүсэн хүлээж, хайж байсан үндэстнийг аврах, Давидын удмын хаанаас хамаагүй давсан ойлголт байлаа. Энэ нь Христ бол бүх бүтээлийн хаан нь мөн гэсэн Матайн тунхаг билээ.

— Доктор Жим Мэйплс

Ингээд бид Матайн Сайнмэдээний түүхэн нөхцөлийг судалсан болохоор одоо уг Сайнмэдээний бүтэц ба агуулгын талаар авч үзэцгээе.

БҮТЭЦ БА АГУУЛГА

Матайн Сайнмэдээний бүтцийн зарим онцлогийн тал дээр эрдэмтэд ихээхэн санал нэгддэг. Ийнхүү санал нэгдсэн нь Матай бидэнд гол түлхүүр ойлголтуудыг өгсөнтэй холбоотой юм. Таван өөр хэсэгт тэрээр Сайнмэдээний гол шилжилтүүдийг харуулахын тулд "Есүсийг эдгээр үгээ гүйцээмэгц..." гэсэн хэллэгийг ашигласан байдаг. Заримдаа ийм хэллэг нь тодорхой бүлэг утга санааны сүүлчийн өгүүлбэр мэт харагддаг бол зарим үед энэ нь шинэ бүлэг утга санааны эхлэл болдог. Гэсэн ч энэ нь үргэлж томоохон шилжилтүүдийг илтгэдэг.


Эдгээр бүтцийн тэмдэглэгээний дагуу ихэнх эрдэмтэд Матайн Сайнмэдээ нь долоон хэсэгт хуваагддаг гэдэгтэй санал нэгддэг. Матай 7:28, 11:1, 13:53, 19:1 ба 26:1 эшлэлүүдэд энэхүү шилжилтийн таван үндсэн хэллэг байдаг. Мөн Матай бас удиртгал ба төгсгөлийн хүүрнэл зэргийг оруулсан байдаг.

- Сайнмэдээ нь Матай 1:1–2:23 багц эшлэл дэх Есүс бол мессиа Хаан юм хэмээх удиртгал хүүрнэлээр эхэлдэг.
- Эхний гол бүлэг утга санаа нь Матай 3:1–7:29 дээр гардаг ба хаанчлалын сайнмэдээг дүрсэлдэг.
- Хоёр дахь гол бүлэг утга санаа нь Матай 8:1–11:1 дээр гардаг бөгөөд хаанчлалын тархалтыг онцолдог.
- Гурав дахь гол бүлэг утга санаа нь Матай 11:2–13:53 дээр байх ба энд хаанчлалын тэмдгүүд болон сургаалт зүйрлэлүүдийг тэмдэглэсэн байдаг.
- Матайн түүхийн дөрөв дэх гол бүлэг утга санаа нь 13:54-өөс эхлээд 18:35-р эшлэл хүртэл үргэлжилдэг бөгөөд итгэл ба агуу байдлын тухай өгүүлдэг.

- Тав дахь буюу сүүлчийн гол бүлэг утга санаа нь Матай 19:1–25:46 дээр байх ба хаанчлалын өнөөгийн эсэргүүцэл болон ирээдүйн ялалтын тухай байна.
- Эцэст нь Матай 26:1–28:20 дээр Хааны үхэл ба амиллын талаар хүүрнэсэн дүгнэлт бий.

Матайн Сайнмэдээний эдгээр хэсэг тус бүр нь тэнгэрийн хаанчлалыг дэлхий дээр авчирсан мессиа Хаан Есүсийн түүхийг илүү дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Эдгээр хэсэг тус бүрийг нарийвчлан авч үзье. Ингээд Матай 1:1–2:23 дээрх танилцуулга хэсгээс эхэлцгээе.

УДИРТГАЛ: МЕССИА ХААН



Матайн Сайнмэдээний удиртгал нь Есүсийг мессиа Хаан гэж танилцуулдаг бөгөөд угийн бичиг, бага нас гэсэн хоёр хүүрнэл хэсгээс бүрдэнэ.

Угийн бичиг

Есүсийн угийн бичгийн талаар Матай 1:1-17 дээр өгүүлдэг. Нэг ёсондоо эхний эшлэл нь утгаа удиртгал буюу гарчиг юм. Энд Матай гол санаагаа хураангуйлж, Есүс бол Израилын мессиа болох Хаан мөн гэсэн байдаг. Матай 1:1 дээр энэ тухай хэлэхдээ:

“Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн бичиг” гэжээ (Матай 1:1).

Матай анхнаасаа Израилын хаан Давид болон Иудейн ард түмний эцэг Абрахам нарт онцгой анхаарал хандуулсан.

Энэхүү удиртгал мэдэгдлийн дараа угийн бичиг нь 2-р эшлэлээс эхэлдэг.

Матай 1:17-р эшлэлийн дагуу угийн бичиг гурван хэсэгт хуваагддаг бөгөөд тус бүр нь арван дөрвөн үеийг агуулдаг. Эхнийх нь Абрахамтай байгуулсан Бурханы гэрээнээс эхэлдэг ба энд Бурхан Абрахамд түүний үр удам дэлхийг захирна гэж амласан тухай өгүүлдэг.

Хоёр дахь хэсэг нь Давид хаанаар буюу Давидын удмыг мөнхөд тогтоосноор Абрахамтай хийсэн гэрээгээ биелүүлэх Бурханы амлалтаар эхэлдэг. Энэ хэсэг нь Бурханы ард түмэн нүгэл үйлдэж, гэрээгээ зөрчсөний улмаас Амлагдсан газраас цөлөгдөж байгаагаар төгсдөг.

Угийн бичгийн гурав дахь хэсэг нь цөллөгөөс Есүсийн төрөлт хүртэл үргэлжилдэг. Израилчууд Бурханы гэрээг зөрчиж, Түүний гэрээний хараалууд дор байлаа. Гэвч Абрахам, Давид нарт амласан амлалтаа биелүүлснээрээ Бурхан Израилыг ерөөх бодолтой хэвээрээ байв. Израилын өмнөх хаад алдаж бүтэлгүйтсэн. Харин эдүгээ Израилын хувь заяаг гүйцэлдүүлэх сүүлчийн Хаан эцэст нь ирлээ. Есүсийн өвөг эцгүүдийн жагсаалт Матай 1:16-р эшлэлд төгсдөг бөгөөд энд хэлэхдээ:

“Иаков нь Христ хэмээгддэг Есүсийг төрүүлсэн Мариагийн нөхөр Иосефын эцэг болой” гэжээ (Матай 1:16).

Ийнхүү Есүс Өөрийн эцэг Иосефоор дамжин Давидын хаан ширээг хууль ёсны дагуу авах бүрэн эрхтэй гэдгийг Матай нотолсон.

Эш үзүүлэгийн илчлэлийн дагуу Мессиа нь Давидын үр удам байх ёстой байлаа. Тиймээс энэ нь Эхлэл ном руу биднийг буцаан хөтөлдөг. Давидын араас гарч ирсэн бүх хаадыг үргэлж л түүнтэй харьцуулж, сайн муу эсэхийг нь тодорхойлсон байдаг. Мэдээж хэрэг Давидын өөрийнх нь байгуулсан гэрээ бидэнд бий. Давид эш үзүүлэгч Натанд хандан ЭЗЭНд зориулан өргөө буюу сүм барих талаар хэлэхэд Натан буцаж ирээд, “Чи ЭЗЭНд өргөө барихгүй, Эзэн чамд зориулж өргөө барих гэж байна” гэдэг. Мөн өргөө гэдгээрээ тэрээр түүний хаан угсааг хэлсэн байдаг. Энэ нь 2Самуел 7 бүлэгт байдаг бөгөөд Бурхан түүнд зориулж өргөө барьж, түүний хаанчлалыг мөнхөд тогтоон, үр удам нь Давидын сэнтийд үүрд хаанчлах болно гэсэн эш үзүүлэлэг нь мессиагийн талаарх эш үзүүлэгийн үндэс болсон юм. Тиймээс эш үзүүлэгчид Давидын хаанчлал, хаант угсаа нуран унасны дараа Бурхан түүний хаант угсааны алдар сууг сэргээнэ хэмээн итгэж найдаж байлаа. Бурхан Давидын удмаас хааныг босгоно гэж тэд хүлээж байсан гэсэг үг. Тиймээс Хаан болох Мессиа нь Давидын удмаас л ирэх ёстой байв.

— Доктор Марк Л. Страусс

Есүсийн угийн бичгийн дараа бид Түүний бага балчир үеийнх нь талаарх хүүрнэлийг олж уншдаг.

Нялх Үеийн Хүүрнэл

Есүсийн нялх үеийн хүүрнэл нь Матай 1:18–2:23 дээр бий. Лукийн Сайнмэдээнд буй 116 эшлэлтэй харьцуулахад энэ хэсэг нэлээд товч бөгөөд ердөө 31 эшлэлтэй байдаг. Энэ хэсэгт Матайн зорилго тун тодорхой хязгаартай байв. Таван богино догол мөр бүр нь Мессиа болох Есүс мэндэлсэн талаарх нэг л чухал баримт дээр анхаарлыг төвлөрүүлэх аж. Догол мөр бүр түүхийг товч өгүүлж, дараа нь тэр түүх нь Хуучин Гэрээний Мессиагийн хүлээлтийг хэрхэн биелүүлж байгааг тайлбарладаг.

Есүсийн нялх үеийн хүүрнэлээс олж мэдсэн хамгийн сонирхолтой зүйлсийн нэг бол түүнд хүмүүн эцэг байгаагүй явдал юм. Үүний оронд Бурхан шууд утгаараа Түүний эцэг байв. Мариа хэдий онгон хэвээр байсан авч Ариун Сүнсээр хэвлийдээ үртэй болсон.

Христитгэлийн зарим шүүмжлэгчдийн хувьд үүнийг Есүсийн уг гарлыг сул тал гэж үздэг. Яагаад гэвэл Түүнийг бие махбодын хувьд Давидын хаан ширээг эзэмших байсан Иосефын удмын хүн биш гэдэг. Гэвч 1Шастир 1–9-р бүлгүүдэд гардаг шиг Библийн угийн бичиг нь үрчилж авсан эцэг эхээр ч дамжин үргэлжилдэг гэдгийг бүгд сайн мэддэг байлаа.

Түүнээс гадна Есүс бол Бурханы Хүү байсан тул Тэрээр бүрэн дүүрэн Бурхан байв. Энэ нь Тэрээр Бурханы гэрээг төгс сахих чадвартай байсан гэсэн үг юм. Гагцхүү хүмүүн хаад нь Бурханы гэрээг хэзээ ч төгс дагаж чадахгүй байв. Иймээс тэд Бурханы Абрахам, Давид нарт амласан гэрээний бүрэн дүүрэн ерөөлүүдийг ч өвлөн авч чадахгүй гэсэн үг юм. Тиймээс, Бурхан Өөрийн гэрээгээ сахин биелүүлэхийн тулд Өөрийн төгс Хүүгээ Хаан болгон илгээж, ингэснээр Түүний ерөөлийн амлалтууд нь биелэгдэх байжээ.

Мессиа Давидын удмаас хүн болж ирэх нь маш тодорхой байсан юм. Мөн энд маш олон чухал үнэн бий. Гэхдээ Мессиа бас Бурхан байх ёстой, бурхан чанартай байх ёстой гэдгийг ойлгох нь үнэхээр чухал. Яагаад ийм юм бол? Эцсийн эцэст, Бурханы өмнө хүн төрөлхтөн бидний гол асуудал бол Түүний эсрэг нүгэл үйлдсэн явдал шүү дээ. Тэрээр уг асуудлыг шийдэх ёстой болсон. Бидний заримдаа ярихыг хүсдэг уучлалын асуудал нь Бурханы өмнөх бидний гэм нүгэл нь зүгээр л Түүний анзаарахгүй өнгөрчих зүйл ерөөсөө биш гэдэгт байдаг. Энэ нь Түүний хувьд "Би дүнг чинь өргөөд тавьчихна" эсвэл "Чи чадахаа л хий" гэж хэлж болох зүйл биш юм. Бурхан бол ариун Бурхан. Бурхан бол зөвт бөгөөд шударга. Бидний гэм нүглийг зүгээр л анзаарахгүй өнгөрчих гэж Түүнд бид хэлж чадахгүй. Энэ нь Тэрээр Өөрийгөө үгүйсгэсэн хэрэг болно. Тиймээс биднийг уучлахын тулд Тэрээр санаачилгыг гартаа авах ёстой болсон. Тэрээр эцсийн эцэст Өөрийн зөвт шаардлагыг хангах шийдлийг гаргаж өгөх болсон гэсэн үг. Бурхан л Өөрөө үүнийг хийх ёстой. Хэрэв та Хуучин Гэрээг уншвал энэ талаар дахин дахин өгүүлсэн байдаг. Жишээ нь “Аврал ЭЗЭНээс ирдэг!” гэх Иона 2:9 дээрх эшлэлийн тухай та бодож болох юм. Энэ бас Бурхан Өөрөө хангах ёстой гэж байна. Энэ нь шийдлийг нь Бурхан Өөрөө өгөх ёстой гэсэн байна. Энэ нь Бурхан Өөрөө уучлах

ёстой гэж байна. Тиймээс хэрэв аврал Мессиагаар дамжуулан явагдах гэж байгаа бол Тэрээр биднийг төлөөлсөн хүн байх ёстой. Мөн тэрбээр Эзэн байх ёстой аж. Ирэх Эзэн. Аврах Эзэн. Ариун байдал ба зөвт байдлаа гүйцээх Эзэн, ийм л учраас Мессиа Бурхан байх ёстой байсан.

— Др. Стивен Ж. Вэллум

Матай Сайнмэдээнийхээ удиртгал хэсэгт Есүсийг мессиа Хаан, Абрахам болон Израилын ард түмэнд Бурханы амласан бүх ерөөлүүдийг хүлээн авсан Давидын хаан Хүү хэмээн танилцуулав. Номынхоо үлдсэн хэсгийн гол сэдэв болох гайхалтай сайхан мэдээний тайзыг Матай ийнхүү зассан харагддаг.

Удиртгалын дараа Сайнмэдээний уран зохиолын таван гол хэсгийг авч үзнэ. Эдгээр таван хуваагдал тус бүр нь хоёр хэсгээс бүрдэнэ. Эдгээр нь Матай Есүсийн юу хийснийг дүрсэлсэн хэсэг, дараа нь Матай Есүсийн юу хэлснийг тайлбарласан ярианы хэсэг юм.

ХААНЧЛАЛЫН САЙНМЭДЭЭ



Матайн Сайнмэдээний эхний үндсэн хэсэг нь тэнгэрийн хаанчлалын Сайнмэдээний түүхийг өгүүлдэг. Энэ хэсэг нь Матай 3:1–7:29 хүртэл үргэлжилдэг.

Мессиа Ирчхээд байна

Хүүрнэлийн хэсэг нь Матай 3:1-р эшлэлээр эхэлж, 4:25-р эшлэлээр төгсдөг. Энд Матай мессиа Хаан ирчхээд байгаа бөгөөд Тэрээр тэнгэрийн хаанчлалыг дэлхийд авчирсан хэмээн тунхаглажээ.

Хүүрнэлийн эхний хэсэг нь Матай 3:1-1-т гардаг. Энд Баптист Иохан

Бурханы Мессиа удахгүй ирж, үнэнч хүмүүст Ариун Сүнсээр баптисм хүртээх тухай өгүүлдэг. Израилд 400 жилийн турш Ариун Сүнсний ажил харьцангуй зогсонги байдалтай байсан шалтгаан нь Өөрийн зөрүүд ард түмнийхээ эсрэг буулгасан Бурханы шүүлттэй холбоотой байв. Харин одоо Хуучин Гэрээний эш үзүүлэгчдийн зөгнөж байсанчлан Бурханы Сүнс цутгагдахад бий болох шинэ өдрийн үүрийн гэгээ цайх гэж байна.

Энэ хүүрнэл Матай 3:13-17-р эшлэлд Есүс баптисм хүртсэнээр үргэлжилдэг. Уг үйл явдалд Ариун Сүнс Есүс дээр буун ирж, мессиагийн үйлчлэлд нь бэлтгэн Түүнийг тосолсон. Тэгэхэд Эцэг Бурхан тэнгэрээс Түүнийг “энэ бол Миний Хүү” хэмээн тунхагласан юм. Энэ нь Түүнийг Дуулал 2:7 дээр өгүүлэх хаан гэдгийг нь харуулдаг.

Тэнгэрээс гарсан дуу хоолой мөн Исаиа 42:1-2 эшлэлүүдэд гардаг "Миний сонгосон, таалдаг Нэгэнийг минь хар" гэсэн үгсээр Есүсийг дүрсэлдэг. Есүс бол хаан Мессиа байсан боловч өөр төрлийн Хаан байх ёстой байв. Тэр зовлонгоор дамжуулан дуудлагаа биелүүлэх болно.

Матай 4:1-11 дээрх хүүрнэлийн дараагийн түүхэнд Сатан Есүсийг хааны зовлонт Мессиагийн дүрд үнэнч байх эсэхийг нь сорьсон байдаг. Тэрээр гурван удаа Есүсийг зовлонгүйгээр Мессиа болох явдалд уруу татсан юм. Ингэхдээ “хүн шиг бүү өлс. Зүдрэлгүйгээр хүмүүсийг итгүүлэн гайхшируул. Зовлон амсалгүйгээр үндэстнүүдийг захир” гэжээ. Гэвч Есүс түүний зовлонт Мессиагийг туулах ёстойг үгүйсгэх хялбар зам бүрээс татгалзсан байна.

Дараа нь Матай 4:12-17 дээр Есүс хаанчлалын Сайнмэдээг номлосноор нийтэд хандсан мессиагийн үйлчлэлээ эхлүүлсэн. Матай 4:17 дээр Есүсийн үгсийг Матай хэрхэн нэгтгэснийг харцгаая. Тэрээр энд:

“Тэр цагаас эхлэн Есүс —Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал айсуу гэж тунхаглаж эхлэв” гэсэн байдаг (Матай 4:17).

Матайн хэлснээр бол Есүсийн номлосон сайхан мэдээ бол тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэсэн юм. Энэ нь чухамдаа Есүс Өөрийн үйлчлэлээрээ дамжуулан тэнгэрийн хаанчлалыг дэлхийд авчрах гэж байгаа тухай байв. Мөн энэ хаанчлал нь нүглээ гэмшиж, Есүсийг хаан хэмээн үнэнчээр дагасан бүх хүмүүст нээлттэй байлаа.

“Тэнгэрийн хаанчлал” гэдэг нь зөвхөн Матайн Сайнмэдээнд гардаг. Энэ нь үнэндээ “Бурханы хаанчлал” гэдэгтэй ижил утгатай гэж би боддог. Энэ хоёр хэллэгийн хооронд ямар ч ялгаа байхгүй гэж хэлдэг ихэнх эрдэмтэдтэй би санал нийлнэ. Есүс хаанчлал ойрхон байна, эсвэл зарим орчуулгад "айсуу" байна гэсэн нь Бурханы эцсийн үеийн засаглал ямар нэг утгаараа Есүсийн мөн чанар болон үйлсэд аль хэдийнээ биелснийг заадаг. Гэхдээ мөн энэ нь бүрэн биеллээ олохыг хүлээж байгаа гэсэн ойлголт бий. Теологийн нэр томъёо нь хаанчлал "бүрэн төгс болох үед" (consummation) бөгөөд энэ нь Христийг хоёр дахиа ирэх үед болох юм. Тэгэхээр Христитгэгчид теологийн хэллэгээр хэлбэл нэлээд диалектик оршихуйд амьдардаг гэсэн үг. Өөрөөр хэлбэл

тэдний нэг хөл нь ирчхээд буй Бурханы эцсийн үеийн хаанчлалд, нөгөө хөл нь хараахан ирээгүй байгаа хаанчлалд байна гэсэн үг. Амьдралын тухай, амьдралын шийдвэрүүдийн талаар, амьдралыг ер нь хэрхэн хардаг талаар, тэнгэрийн хаанчлал зарим талаараа аль хэдийн энд байгаа, нөгөө талаар хараахан ирээгүй гэдэг нь чухам юу гэсэн үг вэ зэргийг хэлэлцэх нь Христэд дагалдуулалд маш том сорилт бэрхшээл болдог.

— Др. Дэвид Р. Бауэр

Сайнмэдээ номуудаас харвал Есүс тосгоноос тосгонд сургаал номлож, "Бурханы хаанчлал айсуй" эсвэл "ойрхон байгаа тул гэмшигтүн" гэснээрээ хэдэн зүйлийг онцолсон байдаг. Тэрээр юуны түрүүнд Бурханы хаанчлал нь Түүний дотор байгаа бөгөөд тэдний дунд байна гэж хэлсэн. Тэрээр эрх мэдэлтэйгээр зааж, чөтгөрийг зайлуулж, тэднээс дээгүүрх эрх мэдэлтэйгээ тунхаглаж, эдгээж чөлөөлж байсан бүхий л үйлчлэлээрээ хэлж, тайлбарлах гэсэн зүйл нь чухам энэ юм шүү дээ. Тиймээс Есүсийн хэлсэн хамгийн эхний зүйл бол Хааны хаанчлал ба эрх мэдэл яг одоо Надад байна, та нарын дунд яг энд байна гэсэн үг байлаа. Гэвч Түүний хэлсэн өөр нэг зүйл бол хаанчлал ирж байна гэсэн ойлголт байв. Хаанчлал энд хараахан бүрэн дүүрэн биелээгүй байгаа боловч ирээдүйд нэг л өдөр Бурханы захиргааны бүрэн байдлыг хүн бүр харах болно. Тиймээс Есүс "Бурханы хаанчлал айсуй" гэж хэлж байхдаа яг л энэ тухай ярьж байсан юм. Тэгэхлээр Бурханы хаанчлал айсуй тул хүмүүсийг гэмшилд уриалснаар Тэрээр тэднийг Хаандаа захирагдахыг уриалсан юм. Тэд захирагдаж, дуулгавартай байснаар, шууд утгаараа Хааныг дагаснаар тэд тухайн үед Бурханы гэрээний ард түмэнд нэгдэж, эсвэл дахин нэгдэцгээж байсан гэсэн үг. Тийм учраас Хаанд захирагдах нэг хэлбэр нь гэмшлээр илэрхийлэгддэг байна.

— Др. Грегори Р. Пэрри

Матай 4:18-22 дээр Есүс дагалдагч нараа дуудсан. Энэхүү зураглал нь хаанчлалынхаа удирдагчдыг бүрдүүлж буй мессиа Хаан гэж харагдана. Үүний дараа Матай 4:23-25 дээр Матай нь Сайнмэдээнийхээ дараагийн хоёр хэсгийг урьдчилан өгүүлсэн. Есүс Галил даяар аялж, олон түмнийг сургаж, эдгээж байсныг тэрээр тунхагласан байдаг. Матай 5–7-р бүлэгт Есүсийн сургаалыг харуулсан бол 8–9-р бүлэгт үйлдсэн эдгэрлүүдийг нь харуулсан байдаг.

Бид хаанчлалын Сайнмэдээний талаарх Матайн хүүрнэлийг авч үзлээ. Харин одоо Матай 5:1–7:29-р эшлэлээс уг хүүрнэлийг дагалдаж хэлэгдсэн сургаалыг хамтдаа харцгаая.

Уулын Сургаал

Энэ яриаг ихэвчлэн Уулын сургаал гэж нэрлэдэг. Энэ сургаалд Есүс хаанчлалын иргэдийн зөвт амьдралыг дүрсэлсэн. Тэрээр хаанчлалын тухай долоон удаа тодорхой дурдсан бөгөөд бүхэлдээ энэ сэдвийг тойрон эргэлддэг.

Зөвт байдлын шаардлага нь Иудейн удирдагчдын төсөөлж байснаас хавьгүй илүү агуу байсныг Есүс үе үе онцолж байв. Тэрээр хаанчлалын иргэдийн тэнгэрлэг Эцэг тэдний төсөөлж байснаас ч илүү ойр бөгөөд ерөөхдөө ч бэлэн байсныг мөн онцолсон. Эдгээр бодлууд хоршин Түүний сургаалд өвөрмөц шинж чанарыг бий болгодог

Уулын сургаалаас зөвхөн нэг жишээ болгон завхайрлын талаарх Есүсийн сургаалыг авч үзье. Бурханы хууль нь зүгээр л уншаад өнгөрөхөөс илүү буюу Иудей багш нарын сургаж байснаас ч илүүг шаарддаг гэж Есүс заасан. Матай 5:27-28 дээр Есүс юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Чи бүү завхайр” гэснийг та нар дуулсан. Харин Би та нарт хэлье. Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийн завхайрсан хэрэг юм” гэжээ (Матай 5:27-28).

Есүсийн "дуулсан" гэж тодотгосон нь Тэрээр тухайн үеийн Иудейн рабби нарын дунд Бичвэрийн нийтлэг тайлбаруудыг ярьж байв. Зарим рабби нар Хуучин Гэрээний тушаалуудад садар самууныг хориглодог гэж заасан боловч хүний зүрх сэтгэлийн хамгийн чухал асуудалд хандан ярьж чадаагүй. Гэвч Есүс Хуучин Гэрээний өдрүүдэд ч үнэн байсан нэг зүйлийг онцолсон. Энэ нь Бурхан зөвхөн гаднах зан үйлийг хянах сонирхолгүй, харин Тэр дуулгавартай байдлыг зүрх сэтгэлээсээ сахиасай хэмээн хүсдэг.

Заримдаа бид Хуучин Гэрээг Шинэ Гэрээний эсрэг зүйлс ярьдаг гэж харах гээд байдаг. Учир нь Хуучин Гэрээнд Бурхан хүмүүсийг хөвч хөндүүлэхийг, тахил өргөхийг, мөн тэднийг онцгой өдрүүдийг тэмдэглэхийг хүсдэг гэх мэт гадаад хэлбэрийг шаарддаг гэж боддог. Эдгээр нь итгэл сүсгийнх нь нэг төрлийн гаднах харагдах хэлбэр байсан. Дараа нь Шинэ Гэрээнд энэ нь одоо зүрх сэтгэлийн итгэл бишрэл болсон харагддаг. Гэвч Бурхан бидний зүрх сэтгэлийг хүсдэг. Тэр бидний хайрыг хүсдэг. Гэхдээ Хуучин Гэрээ, ялангуяа эш үзүүлэгчдийн үгсийг сайтар ажиглавал энэ санаа байсаар ирснийг харж болдог. Эш үзүүлэгч Иоел хэлэхдээ "та нар хувцсаа биш, зүрхээ урж тасчигтун" гэсэн нь итгэл сүсгийн гаднах хэлбэрийг шуудхан эсэргүүцсэн байдаг. Бурхан тэдний зөвхөн гадаад илэрхийллийг харахыг хүсээгүй, харин тэдний зүрх сэтгэлийг, тэдний дотор юу байгааг, мөн хэн бэ гэдгийг нь харахыг хүссэн. Жишээлбэл, Дуулал 103-р бүлгээс та үүнийг бас харж болно. “Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтагтун. Дотор минь байгаа бүгд Түүний ариун нэрийг магтагтун.” Энд дуулаач Бурханы хүмүүс Өөрийг нь ерөөж, тэд чухам хэн бэ гэдгээрээ Эзэнд мөргөхийг уриалсан юм. Тиймээс хайрын

илэрхийлэмж нь Шинэ Гэрээнд л байдаг бөгөөд Хуучин Гэрээнд энэхүү чин сэтгэлийн итгэл сүсгийн талаар байдаггүй гэсэн санаа нь Хуучин Гэрээнд байгаа Бурханы Өөрийн хүмүүстэй хийсэн гэрээний бүрэн бүтэн бодит байдалд нийцэхгүй байна.

— Др. Марк Гигниллиат

Есүс чин сэтгэлээсээ дуулгавартай байхыг онцолсон нь хаанчлалын иргэдийг 5:5 дээр "дөлгөөн", 5:6 дээр "зөвт байдлын төлөө өлсөж, цангагч хүмүүс" гээд, 5:8 дээр "зүрхэндээ цэвэр ариун" гэж дүрслэхэд хүргэсэн. Тэнгэрийн хаанчлал бүрэн дүүрэн биеллээ олох хүртэл Түүний дагалдагчид ийм төрлийн иргэн болж бүрэн өөрчлөгдөхгүй гэдгийг Есүс мэдэж байсан нь ойлгомжтой. Гэвч Тэр үүнээс өмнө тэднийг зөвт шударга байхыг уриалсан хэвээрээ л байв. Матай 5:48 дээр Түүний хэлсэн үгийг сонсоцгооё. Энд:

“Тиймд тэнгэрлэг Эцэг чинь төгс байдаг шиг та нар мөн төгс бай” гэжээ (Матай 5:48).

Нэг талаараа энэ тушаалыг биелүүлэх боломжгүй. Хэн ч Бурхан шиг төгс байж чадахгүй шүү дээ. Гэхдээ энэ нь биднийг цөхрөлд хүргэх ёсгүй. Харин ч эсрэгээрээ Есүс бидэнд нигүүлсэл, урам зоригоор дүүрэн амлалт өгсөн. Есүс энэхүү сургаалаараа дамжуулан үнэнч дагалдагчдадаа хандан тэнгэрийн хаанчлал биднийх болсон гэдгийг баталсан юм.

Жишээлбэл, Матай 5:3-10 дээрх Ерөөлтэй еэ сургаалаас бид найман ерөөлийг олж хардаг. Дунд хэсэгт нь байгаа зургаад нь тэнгэрийн хаанчлал бүрэн дүүрэн ирэх тэр өдөр ерөөлүүдийг хүлээн авна гэж амлаж байна. Гэхдээ эхний болон сүүлчийн ерөөлүүд өөр өөр байдаг. Есүс Өөрийн ард түмэн нь хаанчлалын эдгээр ерөөлүүдийг аль хэдийн авсан гэж хэлсэн байна. Матай 5:3 болон 10-р эшлэлүүдэд Есүс эдгээр ерөөлүүдийн талаар юу гэж хэлснийг харцгаая. Энд:

“Сүнсэндээ ядуус ерөөлтэй еэ! Тэнгэрийн хаанчлал тэднийх юм. Зөвт байдлын төлөө хавчигдагсад ерөөлтэй еэ! Тэнгэрийн хаанчлал тэднийх юм” гэжээ (Матай 5:3, 10).

Есүсийг дагах жинхэнэ том сорилт нь Бурханы хаанчлалын хүч биднийг аль хэдийн Түүний хаанчлалын зөвт иргэд болгон хэдийн хувьсган өөрчилж байна гэсэн агуу амлалттай нийцдэг.

Сайнмэдээнийхээ эхний гол хэсэгт Есүсийн үйлчлэлийн зорилго, агуулга дээр анхаарлаа хандуулах замаар Матай нь хаанчлалын Сайнмэдээг онцолсон. Есүс бол тэнгэрийн хаанчлалыг Бурханы ард түмэнд авчирсан мессиа Хаан байсан. Тэр тэдэнд амьдралыг хувьсган өөрчлөн энэхүү хаанчлалын хүч чадлын тухай заасан. Мөн Тэрээр хэрэв тэд үнэнч итгэмжит байвал хаанчлал бүрэн дүүрэн ирэх үед агуу ерөөлүүдийг өвлөх болно хэмээн тэдэнд амласан.

ХААНЧЛАЛЫН ТЭЛЭЛТ



Матайн Сайнмэдээний хоёр дахь том хэсэгт хаанчлалын тархалтын тухай өгүүлдэг. Энэ нь Матай 8:1–11:1 хүртэл үргэлжилдэг.

Есүсийн Гайхамшиг ба Хариу үйлдлүүд

Хаанчлалын тэлэлтийн тухай хүүрнэл нь Матай 8:1–9:38 дээр гардаг. Энэ нь Есүсийн гайхамшгуудын тухай болон эдгээр гайхамшгуудад янз бүрийн хүмүүс ямар хариу үйлдэл үзүүлсэн тухай түүхүүдээс бүрддэг.

Энэхүү хүүрнэл нь нийт 11 хэсгээс бүрддэг. Эдгээрт 8:1-4 дээрх Есүс ба уяман өвчтөн, 8:5-13 дээрх зуутын даргын зарц, 8:14-17 дээрх Петрийн хадам эх, 8:18-27 дээрх шуурга, 8:28-34 дээрх чөтгөр шүглэсэн хоёр, 9:1-8 дээрх саа өвчтөн, 9:9-17 дээрх татвар хураагчид ба нүгэлтнүүд, 9:18-26 дээрх охин ба эмэгтэй, 9:27-31 дээрх хараагүй хоёр эр, мөн 9:32-34 дээрх чөтгөр шүглэсэн өөр нэгэн хүний тухай тус тус өгүүлдэг. Тэгээд энэ хэсэг нь 9:35-38 дээр Есүсийн энэрэнгүй сэтгэлийг дүрсэлснээр төгсдөг.

Хугацаа хүрэлцэхгүй тул Есүсийн амьдралд тохиолдсон эдгээр үйл явдлын талаар цөөн хэдэн ажиглалтыг л хийцгээе. Тэрээр 8:1-4 дээр уяман өвчтэй хүнийг, 8:5-13 дээр зуутын даргын зарцыг, 8:14-17 дээр Петрийн хадам эхийг, 9:1-8 дээр саа өвчтэй хүнийг, 9:20-22 дээр цус алддаг өвчтэй эмэгтэйд эдгээж, 9:27-31 дээр хоёр хүнийг хараа оруулснаараа өвчин зовлонгоос дээгүүр орших хаанчлалын эрх мэдлээ хэрэгжүүлсэн юм.

Тэрээр мөн Матай 9:18-26 дээр үхсэн охиныг амилуулж, үхлээс дээгүүрх эрх мэдэл, хүч чадалтай гэдгээ нотолсон. Есүс Матай 8:23-27 дээр шуургыг намдааснаар байгаль дэлхийг захирдаг гэдгээ харуулсан.

Үүнээс гадна Есүс Матай 8:28-34 дээр булшнуудын дунд амьдарч байсан хоёр

хүнээс, мөн 9:32-34 дээр чөтгөр шүглэсэн, хэлгүй хүнээс чөтгөрүүдийг хөөн зайлуулж, Сатаны хаанчлалыг захирах хүчээ харуулсан. 9:9-17 дээр Матайг дагалдагчаа болгон дуудсан нь Есүсийн татвар хураагчид болон нүгэлтнүүдтэй харилцах харилцааны талаар тодорхой харуулдаг. Есүс Матайг татвар хураагчийн амьдралаа орхиж, шинэ амьдралаар амьдар хэмээн дуудсан. Энэ өөрчлөлтийг гайхамшиг гэхээс өөр юу гэх вэ. Татвар хураагчид болон нүгэлтнүүдийн өөрчлөлт маш гайхалтай байсан тул Матай тэдэнтэй хооллож буй Есүс рүү тэр даруй очсон юм. Тиймээс тэрээр тэдэнд байсан баяр хөөрийн шалтгааныг тайлбарлах шаардлагатай болжээ.

Матай Есүсийн хүч чадалд анхаарал хандуулснаас гадна үүнд нь олон нийт хэрхэн хандаж байгааг анзаарч үзэхийг хүссэн. Шуудхан хэлэхэд тэд гайхаж хоцорсон юм. Бид үүнийг Матай 8:27, 34, 9:8, 26, 31, 33 зэрэг эшлэлүүдээс хардаг. Тэдний энэхүү гайхширал нь ихэвчлэн Есүсийг эсэргүүцэхэд хүргэсэн.

Зарим нь зүгээр л үл итгэснээр Есүсийг эсэргүүцсэн. Бусад хүмүүс, ялангуяа еврей удирдагчид түүнийг ил тодоор шүүмжилсэн. Матай 8:34 дээрээс харвал зарим нь Есүсээс эмээж байлаа. Бусад нь Матай 9:3 дээр өгүүлснээр айж, цочирдсон. Заримдаа, 9:14 дээрээс харвал Есүсийг эсэргүүцэж буй нь сайн санаж хэлсэн мэт харагддаг ч үнэндээ буруу гэдэг нь харагддаг. Мөн заримдаа хүмүүс Матай 9:34-т өгүүлдэг шиг үнэн гэж мэддэг зүйлээсээ санаатайгаар татгалзсанаараа Есүсийг эсэргүүцдэг байв. Харамсалтай нь Есүсийн үйлчлэл үргэлжлэх тусам Түүнийг эсэргүүцэх нь улам бүр нэмэгдсээр байв.

Шинэ Гэрээг харвал хүмүүс гайхамшгуудыг өөрийн нүдээр үзсэн боловч Христийг яаж үгүйсгэж чадаж байна вэ гэдэг нь хамгийн том оньсого болох биз. Хүмүүс Түүний хийсэн зүйлд дахин дахин алмайран гайхширч байсан гэж Бичвэр хэлдэг. Тэгсэн атлаа тэд яагаад Түүнийг эсэргүүцэх болов оо? гэдэгт Матай 22:29 хариулна гэж би бодож байна. Энд Есүс Фарисайчуудад хандан, та нар Бичвэрийг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээсээ болж төөрөлдөж байна гэсэн байдаг. Одоо энэ хам сэдэвт бол Тэрээр Садукайчуудад хандсан байгаа боловч хуулийн багш нар болон фарисайчуудад ч мөн адил зүйлийг хэлэх байсан гэж би боддог. Тэд хүмүүсийг алдаатай сургаалыг заасан. Тэд ирэх Мессиагийн талаарх хүлээлтийг буруу сургаалаараа хэлбэршүүлчихсэн байсан юм. Энэ нь хүмүүст буруу зааж, хүмүүст хуурмаг найдлага бий болгож, Бурханы Үгийг буруугаар ашиглаж буй хүмүүст буюу өнөөдөр бидэнд маш том сургамж өгч байна шүү дээ. Анхны зууны Израилд яг ийм л зүйл тохиолдсон гэж харагддаг. Тэд Мессиа ирнэ гэж хүлээж байсан бөгөөд энэ нь үндэсний ялалт байсан гэж та хэлж болох юм. Тэгтэл Есүс ирсэн. Хэдийгээр Тэрээр тэдний хэзээ ч харж байгаагүй, дахиж хэзээ ч харахгүй зүйлсийг үйлдсэн ч тэд Түүнийг эцсээ хүртэл эсэргүүцсэн. Учир нь тэдгээр удирдагчид үргэлж л Түүний гайхамшгийг үл хэрэгсэн гутааж байсан. Тэд Түүнийг эдгээр гайхамшгуудаа Сатантай эвсэн хийж байна гэж л дүгнэхийг хүссэн. Эцэст нь харамсалтай нь олон арван жил, үе

дамжсан буруу сургаал болоод эрх мэдэлтэй, шашны эрх мэдэл бүхий хүмүүсийн дайралт нь хэдий гайхамшгуудыг харсан ч эцэстээ олон хүмүүсийн зүрх сэтгэлийг Христээс холдуулсан юм.

— Др. Жим Мэйплс

Матай 9:35-38 дээрх Есүсийн хүчирхэг гайхамшгуудын тухай энэхүү хүүрнэлээ тэрээр Есүс цугласан олныг өрөвдсөн тухай өгүүлснээр дуусгажээ. Матай 9:36-38 дээрээс энэ түүхийг харцгаая. Энд:

“Хүмүүсийг хараад Тэр өрөвджээ. Учир нь тэд хоньчингүй хонь мэт хаягдан туйлдсан байлаа. Тэгээд Тэр шавь нартаа хэлэхдээ —Ургац арвин ч ажилчид цөөн байна. Тиймээс ургацдаа ажилчид явуулахыг ургацын Эзэнээс гуйцгаа гэв” гэжээ (Матай 9:36-38).

Ард түмэн нь Өөрийг нь хаан болгон хүлээж аваагүйн нэг шалтгаан нь тухайн үеийн олон удирдагчид тэдэнтэй зүй бус харьцаж, буруу сургаалыг зааж байснаас болсон гэдгийг Есүс мэдэж байсан. Гэвч Өөрийнх нь гайхамшгууд тэдний зүрх сэтгэлийг зөөлрүүлж, Өөрийг нь дагахад хүргэж байгааг Тэр бас мэдэж байв. Тиймээс Тэрээр газар дээр буй Бурханы тэнгэрлэг хаанчлалд төөрсөн хүмүүсийг авчрах, хэрхэн зөв шударга иргэн байхыг заах Сайнмэдээг тунхаглагчид болон зөвт удирдагчдыг Бурхан босгохын төлөө залбирахыг дагалдагч нартаа захисан.

Хааны Төлөөллүүд

Хаанчлалын тэлэлтийн талаарх Матайн хүүрнэлийг судалсан тул одоо Матай 10:1–11:1 дээр юу өгүүлж буйг авч үзье. Энэхүү яриа нь хааны төлөөллүүд буюу төлөөлөгч нар болох дагалдагч нарт гол анхаарлаа хандуулдаг. Энэ хэсэгт Есүс өмнөх хүүрнэлийн төгсгөлд хөндсөн асуудалд хариулсан байдаг. Есүс дагалдагчдадаа Сайнмэдээг тунхаглагч, удирдагчдыг босгохын тулд Бурханаас залбирахыг тушаасны дараа арван хоёр дагалдагчдаа үйлчлэлд хүчирхэгжүүлсэн. Тэрээр яг л Өөр шигээ үг болон үйлдлээрээ хаанчлал ирснийг тунхаглах тушаалыг өгснөөр Өөрийн хаанчлалаа өргөжүүлэн тэлсэн юм. Матай 10:7-8 дээр Есүс тэдэнд энэ талаар тушаасан байдаг. Энд:

“Та нар явахдаа "Тэнгэрийн хаанчлал айсуй" гэж тунхаглагтун. Өвчтэйг нь эдгээ, үхэгсдийг босго, уяман өвчтэйг нь цэвэрлэ, чөтгөрийг зайлуул. Үнэгүй авснаа үнэгүй өг” гэжээ (Матай 10:7-8).

Есүс дагалдагч нараа илгээхээсээ өмнө олон анхааруулга хэлсэн. Тэд Есүсийн үлгэр жишээг дагавал амьдрал нь амаргүй болох байсан. Дэлхий тэдэнд эелдэг хандахгүй. Тэд зовж шаналах болно. Тэднийг шоолж, баривчилж, алах болно. Гэвч Есүс тэдний үйлчлэл тэнгэрлэг Эцэгээр ерөөгдөх бөгөөд эцэст нь хаанчлал тэднийх болно хэмээн амласан. Матай 10:39 дээр Есүс дагалдагч нараа хэрхэн тайвшруулсныг сонсоорой. Тэрээр энд:

“Амиа ологч нь түүнийгээ алдах болно. Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно” гэжээ (Матай 10:39).

Есүсийн заасан, эдгээсэн үйлчлэлээс болж Есүсийн дагалдагч нар нь өмнөх амьдралаа орхиж байсан. Гэвч Хаан болох Есүстэй Өөртэй нь хамт байж, жинхэнэ хаанчлалын амьдралыг тэд олж авна гэж Есүс тэдэнд батлан өгүүлсэн.

Матай Сайнмэдээнийхээ энэ хоёр дахь үндсэн хэсэгтээ хаанчлалын тэлэлтийг ялангуяа Есүсийн хүч чадлын үйлс ба Есүсийн дагалдагч нартаа өгсөн зааварчилгаагаар хэрхэн явагдсан болохыг тайлбарласныг бид харлаа. Энэ нь орчин үеийн чуулган дахь бидний үйлчлэлд сайн загвар болж өгдөг. Бид Есүсийн хүчинд найдаж, үнэнч дагалдагчийн ёсоор Түүнд үйлчилбэл Есүс биднээр дамжуулан хаанчлалаа байгуулж, бидэнд тэнгэрлэг ерөөлөө буулгах болно.

ТЭМДЭГ БА СУРГААЛТ ЗҮЙРЛЭЛ



Матайн Сайнмэдээний гурав дахь үндсэн хэсэгт Хаан болох Есүсийг мөн Түүний хаанчлалыг тэмдэг ба сургаалт зүйрлэлээр үргэлжлүүлэн харуулдаг. Энэ нь Матай 11:2–13:53 дээр бий.

Тэмдэг ба Хариу үйлдлүүд

Матайн хүүрнэл нь Есүсийн үйлдсэн тэмдгүүд болон Түүний тэмдгүүдэд үзүүлэх хариу үйлдлүүдэд төвлөрөх ба энэ нь Матай 11:2-12:50 хүртэл үргэлжилдэг. Эдгээр тэмдгүүд нь Хаан болон Түүний хаанчлал ирж байгааг харуулж, хаанчлал ямар харагдах бол гэсэн хуурамч хүлээлтийг зассан байдаг. Үүний үр дүнд нэгэнт эхэлсэн байсан шүүмжлэл улам илүү авч эхэллээ.

Энд буй цуварсан үйл явдлуудыг таван хэсэгт хуваадаг. Матай 11:2-19 дээр Есүс Өөрийнх нь тэмдгүүд Түүнийг Хуучин Гэрээний эш үзүүлэгийг гүйцэлдүүлсэн Мессиа мөн гэдгийг баталж буй талаар Баптист Иоханд нотлон өгүүлсэн байдаг. Тэгээд Тэрээр ард түмнийг Түүний тэмдгүүдэд гэмшлээр хариу үйлдэл үзүүлэхийг уриалсан. Есүс 11:20-30-р эшлэлд гайхамшгуудыг үйлдсэн хотууддаа хандан, гэм нүглээ гэмшээгүй хүмүүст сэрэмжлүүлэг өгч, Өөрт нь ирэх хүмүүст амралт өгнө хэмээн амласан. Тэрээр энэ талаар Матай 11:30 дээр өгүүлдэг. Энд:

“Буулга минь аятай, ачаа минь хөнгөн гэв” гэсэн байна (Матай 11:30).

Матай 12:1-21 дээр Есүсийн тэмдгүүдэд фарисайчуудын үзүүлсэн хариу үйлдлийг тодорхой харуулж эхэлсэн байдаг. Эхлээд тэрээр Есүс Амралтын өдөртэй холбоотой Бурханы зорилгын талаар фарисайчуудтай хэрхэн маргасан талаар өгүүлдэг. Ингээд Амралтын өдөр хүнийг эдгээснээр эрх мэдлээ харуулж буйг онцолдо. Энд Есүс Амралтын өдөр нь хүнийг эдгээж, амийг аврах зорилготой хэмээн сургасан байдаг.

Матай 12:22-37 дээр олон түмэн Есүсийн гайхамшгуудыг хараад гайхширч байсан ч Фарисайчууд Түүнийг Беелзебүлийн хүчээр тэдгээрийг үйлдсэн гэж буруутгав. Хуулийн багш нар Түүнийг Мессиа гэж хүлээн авахын оронд чөтгөрт эзэмдүүлсэн гэдэгт итгэж байв.

Матай 12:38-50 дээр фарисайчууд хоёр нүүр гарган өөр тэмдэг үзүүлэхийг шаардсан боловч Есүс тэдэнд зөвхөн Ионагийн тэмдгээс өөр тэмдэг өгөгдөхгүй гэж анхааруулсан юм. Тэгвэл энэ нь ямар тэмдэг байсан бэ? Энэ нь Иона гурван өдрийн дараа аварга том загаснаас гарч, харь үндэстэн Ниневег нүглээ гэмшихэд хүргэсэнтэй адил Есүс гурав хоногийн дараа үхлээс амилж, бусад олон харь үндэстнүүдийг нүглээ гэмшихэд хүргэнэ гэсэн утгатай байлаа.

Гэм нүглээ гэмших аль ч үндэстний хэнийг ч бай Бурхан хүлээн авна гэдгийг харуулахын тулд Есүс Өөрийн төрөлх эх, ах дүү нараа хүртэл Өөрийнх нь гэр бүл биш хэмээн хэлсэн байдаг. Харин Матай 12:49-50 дээр Тэрээр энэ тухай хэлэхдээ:

“—Харагтун, Миний эх ба ахан дүүс энд байна. Тэнгэр дэх Эцэгийн минь хүслийг биелүүлэгч хэн боловч Миний ах эгч, дүүс болон эх мөн” гэв (Матай 12:49-50).

Ингээд бид Есүсийн үйлдсэн тэмдгүүдийн талаарх Матайн хүүрнэлийг ярилцлаа. Оддоо Матай 13:1-53 дээр буй Есүсийн хаанчлалын сургаалт зүйрлэлүүдийн талаарх яриа руу нь орцгооё.

Хаанчлалын Сургаалт зүйрлэлүүд

Матай номд Есүсийн айлдсан алдартай сургаалт зүйрлэлүүдийг таван хэсэгт хуваан танилцуулдаг. Эдгээр нь 13:1-23 дээрх тариачны сургаалт зүйрлэл, 13:24-30 дээрх үрийн сүүлийн сургаалт зүйрлэл, 13:31-43 дээрх гичний үр ба хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл, 13:44-46 дээрх нуусан эрдэнэ ба сувд, мөн 13:47-53 дээрх

торны тухай сургаалт зүйрлэл юм. Уг сургаалт зүйрлэлүүд нь Бурханы хаанчлалын талаарх буруу ойлголтуудыг засах зорилготой байв.

Зарим сургаалт зүйрлэлд тухайлбал, 13:31-32 дээр гичний үр, 33-р эшлэлд хөрөнгө, 44-р эшлэлд эрдэнэ, 45-46-р эшлэлд сувд зэрэг байдлаар Есүс тэнгэрийн хаанчлалыг дээд туйлын үнэ цэнтэй бөгөөд ямар ч үнээр хамаагүй эрэлхийлэх ёстой зүйл хэмээн дүрсэлсэн. Энэ нь эхэндээ ач холбогдолгүй мэт санагдаж болох ч хэзээ нэгэн цагт сүр жавхлантайгаар үзэгдэх аж.

Гэвч Хаан болон Түүний хаанчлалыг хүлээн аваагүй Израилын алдаанд төвлөрч байгаагаа Есүс өөр сургаалт зүйрлэлүүдээрээ хэлсэн. Матай 13:1-23 дээр тариачны тухай сургаалт зүйрлэл ба тайлбар нь бий. Энд Тэрээр итгэлд олон саад бэрхшээл байгаад зогсохгүй ихэнх хүмүүс хаанчлалыг үгүйсгэнэ гэдгийг тодорхой хэлсэн.

Энэ санааг 24-30, 36-43-р эшлэлүүдэд хогийн ургамлын талаарх сургаалт зүйрлэл болон 47-51 дээрх торны тухай сургаалт зүйрлэлээр бататгав. Есүс олон хүн хаанчлалыг хүлээн авахаас татгалзаж, эцэст нь устгагдах болно хэмээн сургажээ. Эдгээр сургаалт зүйрлэлүүд нь Есүсийг эсэргүүцдэг хүмүүст тодорхой анхааруулга болсон. Тэд үл итгэгчдэд гэмшиж, цор ганц жинхэнэ Хааны үнэнч дагалдагчид болох боломж олгосон.

Христ ирчихсэн. Тэрээр эш үзүүлэгчдийг биелүүлсэн. Тэр Өөрийн хаанчлалаа авчирсан. Гэвч энэ нь бас оргил үеэ хүлээсээр байна. Христитгэгчдийн хувьд бид энэ хаанчлалд ордог. Гэхдээ бид өөрсдийн нэн тэргүүнд тавьж буй зүйлсээ эргэн дахин үнэлж дүгнэх ёстой. Түүнийг зохих ёсоор дагаагүйдээ гэмшиж, амьдралдаа Түүний хүслийг үнэнчээр эрж хайн, үүнийх нь дагуу алхаж буй эсэхээ шалгаж байх хэрэгтэй. Түүний үнэ цэнийг баримталж, хаанчлал бүхэлдээ юуны тухай ярьж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс Эш үзүүлэгч, Тахилч, Хаан болсон Түүний өмнө очиж байнга гэмшин, нүглээ улайх шаардлагатай байдаг. Энэ дэлхийд бидэнд зориулан бий болгосон Түүний зорилгыг хэрэгжүүлэн, Түүнийг дагаж, Түүнд үйлчлэхийг эрэлхийлэх нь чухал билээ.

— Др.Стивен Ж. Вэллум

Бид Христитгэгчдийг Бурханы хаанчлалын ирэлтийг хүсэн тэмүүлэхэд урамшуулах ёстой. Нэгдүгээрт, хувь хүний хувьд тэнгэрийн хаанчлалын эрх мэдэл нь бидний амьдралын хүч юм. Энэ нь биднийг Бурханд захирагдаж, Түүнд төвлөрсөн амьдралаар амьдрахад түлхэц өгдөг бөгөөд ингэснээр бидний амьдралд илэрч буй Бурханы эрх мэдэл нь бидний сүнслэг амьдралын зорилго болдог. Хоёрдугаарт, бид аврал золилтын түүхийн үүднээс тэнгэрийн хаанчлалын талаарх ойлголтыг сурах хэрэгтэй. Энэ нь хэрхэн эхэлж, илчлэгдэж, Түүний авралын төлөвлөгөөг гүйцээж

байгааг бид сурна. Дараа нь тэнгэрийн хаанчлалын сургаал нь Хуучин ба Шинэ Гэрээг нэгтгэж буйг бид харах болно. Бидний золигч Бурханы агуу төлөвлөгөөг харж, Түүний цогц зорилгыг төвөггүй ойлгож ухаарахад эдгээр сургаал бидэнд тусалдаг. Гуравдугаарт, тэнгэрийн хаанчлал нь ертөнцийг үзэх үзлийн талаарх библийн зөв зүйтэй үзлийг бий болгож, бүх зүйл Бурханых гэдгийг ойлгоход бидэнд тусалдаг. Түүний хаанчлал бүрэн гүйцэд болж, дэлхий дээрх бүх ёрын муу хүчийг шүүж, устгах болно. Учир нь Бурхан Өөрөө туйлын дээд Хаан юм. Тиймээс бид цаашид зөвхөн Өөрийнхөө төлөө амьдрахаа больсон. Бид хөршүүд, нийгэм ба энэ дэлхийн сайн сайхны төлөө санаа тавихыг хүсдэг. Бид өөрсдийн эргэн тойронд төдийгүй алсад байх зүйлсэд ч мөн анхаарлаа хандуулах хэрэгтэй. Нийгмийн амьдралд орж, бүх талбарыг нь хувьсган өөрчлөх нь бидний үүрэг байх хэрэгтэй.

— Др. Стефен Чан, орчуулга

ИТГЭЛ БА АГУУ БАЙДАЛ



Матайн түүхийн дөрөв дэх үндсэн хэсэг нь 13:54-р эшлэлээс эхлээд 18:35 эшлэл хүртэл үргэлжилдэг. Энд итгэл ба агуу байдлын тухай өгүүлдэг. Уг хэсэгт Есүсийн хаанчлалд агуу байх үнэнч дагалдагч байна гэдэг нь ямар утгатай болохыг илчлэн харуулдаг.

Есүст Итгэхийг Эсэргүүцсэн нь

Энэ хэсгийн хүүрнэл нь 13:54–17:27 хүртэл үргэлжилдэг бөгөөд нэг

эмэгтэйгээс бусад нь бүгд Есүст бүрэн дүүрэн итгэхийг эсэргүүцсэн тухай өгүүлдэг. Ингэхдээ үүнд янз бүрийн арга замуудыг дурдсан арван гурван цувралыг багтаажээ. Эхний хоёр цуврал нь Есүст итгэх итгэлийг бүхэлд нь үгүйсгэсэн хоёр тохиолдлыг онцолдог. Нэгдүгээрт, 13:54-58 дээр Есүс Назарын төрөлх хотдоо ирэх үед Түүнийг мэддэг хөршүүд нь Түүний гайхамшгуудыг үйлдэх чадварын талаар маргаагүй. Гэвч тэд үл итгэсэн хэвээр байж, Түүнийг үгүйсгэсэн. Тэдний итгэлгүй байдлаас болж Тэр тэнд олон гайхамшиг үйлдээгүй талаар бид 13:58-р эшлэлээс уншдаг.

Дараа нь 14:1-12 дээр Херод болон Баптист Иоханы үхлийн тухай гарна. Херод Иоханд гаргасан үйлдлийнхээ төлөө Бурханы шүүлтийг хүртэх ёстой байв. Гэхдээ үүнээс илүүтэйгээр 1-р эшлэлд Херод Есүсийн гайхамшгуудын талаар маргаагүй талаар тайлбарласан нь бий. Үүний оронд түүний зөвлөхүүд нь Есүсийг үхлээс буцан ирж Херодыг зовоох гэж буй Баптист Иохан байна гэж итгэсэн байжээ.

Дараагийн гурван цувралд Есүсийн дагалдагч нар болон тэд хэрхэн итгэлээр өсөх хэрэгтэй байсан тухай төвлөрч харуулсан. Матай 14:13-21 дээр Есүс таван мянган хүнийг хооллосон тухай түүх гардаг. Есүс дагалдагч нартаа Өөрийг нь дагасан олныг хооллохыг тушаасан боловч 15-р эшлэлд дагалдагч нар нь хоол хүнс хүрэлцэхгүй байна хэмээн Түүнд гомдоллож, эргэлзсэн байдаг. Тийм учраас Есүс тэдний хоол хүнсийг ерөөж, таван мянган хүнд хүрэхүйц хангалттай болгон, Өөрийн хүчийг батлан харуулжээ.

Матай 14:22-36 дээр Есүс усан дээр алхсан. Эхлээд Петр завинаас бууж Есүст итгэж байгаагаа харуулсан боловч аюулыг хараад эргэлзэж, далайд живж эхлэв. Түүнийг аварсны дараа Есүс 31-р эшлэлд "—Өчүүхэн итгэлт минь ээ, чи юунд эргэлзэв?" гэжээ.

Матай 15:1-20 дээр Есүс болон зарим фарисайчуудын хоорондох зөрчилдөөн гардаг. Петр Есүсээс Түүний хэлсэн энгийн зүйлийн талаар тайлбар хүссэн. Тиймээс 16-р эшлэлд Есүс "—Та нар ч бас ойлгохгүй хэвээр байна уу?" гэж дургүйцэнгүй асуусан байдаг.

Эдгээр үйл явдлуудад Есүст баттай итгэсэн цор ганц тохиолдол гардаг. Энэ нь 15:21-28 дээрх чөтгөрт эзэмдүүлсэн охинтой Канаан эмэгтэй юм. Бусдаас ялгаатай нь тэрээр өөрт нь туслаач гэж Есүсээс гуйсан. 28-р эшлэлд Есүс "Эмэгтэй, итгэл чинь агуу юм!" гэж сайшаан хариулсан байдаг.

Тэгээд Матай итгэл багатай Есүсийн дагалдагчдын талаар дахин өгүүлдэг. Тэрээр 15:29-39 дээр дөрвөн мянган хүнийг хооллосон тухай бичсэн. 33-р эшлэлд дагалдагч нар нь Есүсийг өмнө нь таван мянган хүнийг хооллож байхыг харсан боловч хангалттай хоол хүнс хаанаас олж чадахаа мэдэхгүй асуусан тухай өгүүлдэг.

Матай 16:1-12 дээр Есүс фарисайчууд, садукайчуудтай маргалдсан. Нэгэн удаа Тэрээр дагалдагч нартаа хандаж, "фарисайчуудын хөрөнгөний" талаар сэрэмжлүүлжээ. Тэгэхэд тэднийг талх авч ирээгүй болохоор Түүнийг уурласан байна гэж тэд боджээ. Гэвч Есүс өмнө нь мянга мянган хүнийг талхаар хооллож байсан үеэ тэдэнд сануулж, "—Өчүүхэн итгэлтнүүд ээ" хэмээн 8-р эшлэлд дагалдагч нараа дуудсан.

Үүний дараа бид хоорондоо нягт холбоотой хоёр цувралыг олж харна. Нэг талаас, 16:13-20-р эшлэлд Петрийн олонд танигдсан итгэлийн тунхаг гардаг. 16:16 дээр Есүсийн талаар "—Та бол Христ, амьд Бурханы Хүү" гэж Петр тунхагласан. Есүс итгэлийнх нь төлөө Петрийг магтаж, ерөөв.

Харин нөгөө талаас, Есүс Петрийг яг адилхан хатуу зэмлэсэн талаар 16:21-27

дээр гардаг. Есүс зовлон эдэлж, үхэхийн тулд Йерусалим руу явах гэж байгаагаа дагалдагч нартаа эхлэв. Тэгэхэд Петр эсэргүүцсэн тул Есүс 23-р эшлэлд түүнд «— Миний араас зайл, Сатан аа!» гэж хатуухан хариулжээ. Есүс үүнийгээ Петрийг Бурханыхаар бус харин хүнийхээр боддог гэж тайлбарлав.

Энэ зэмлэлийн дараа бид 17:1-13 дээрээс Есүсийн хувиран өөрчлөгдсөн тухай олж уншаг. Дагалдагч нар нь Есүсийн сүр жавхлант байдлыг хараад, тэр газарт цацар барьж өгөхийг хүссэн. Гэвч 12-р эшлэлд Есүс үхэж, үхлээс амилсныхаа дараа л жинхэнэ алдар сүр нь харагдах болно гэдгийг тэдэнд сануулсан.

Матай 17:14-23 дээрээс бид чөтгөр шүглэсэн хүүгийн тухай уншдаг. Есүсийн дагалдагч нар чөтгөрийг зайлуулах гэж оролдсон боловч чадаагүй. Тэгээд Есүс Өөрөө хөөснийхөө дараа 20-р эшлэлд Тэрээр "Та нарын итгэл өчүүхнийх" гэж хэлсэн.

Эцэст нь 17:24-27 дээр татвар хураагчид Есүсийн дагалдагч нар дээр ирж, Түүнийг сүмийн татвар төлсөн эсэхийг нь асуув. Петр тун хурдан, магадгүй айсандаа Есүсийг төлсөн гэж хариулав. Дараа нь Петр мөнгө авахаар Есүс дээр ирсэн бөгөөд Есүс гайхамшиг үйлдээд түүнийг санаа зовох шаардлагагүй гэдгийг тайлбарлав.

Матай Есүсийг үгүйсгэсэн хүмүүс болоод түүнд итгэсэн канаан эмэгтэйд ийнхүү дурдсанаараа дагалдагчид Есүст итгэх итгэлээ өсгөх хэрэгцээтэйг харуулахыг зорьжээ.

Матай 18:1-35 дээр дахин нэг удаа Есүсийн яриаг өөрийн хүүрнэлдээ өгүүлсэн байдаг. Энэхүү яриа нь Бурханы хаанчлалын гэр бүл дэх жинхэнэ агуу байдлын тухай буюу Бурханы хаанчлалын ах, эгч, дүүс нарын дунд даруугаар үйлчилснээр ирдэг агуу байдлын тухай өгүүлдэг.

Хаанчлалын Гэр бүл дэх Агуу байдал

Өмнөх бүлгийн сүүлчийн хэсэгт Есүс Өөрийн дагалдагчдыг Хаан болох Бурханы хөвгүүд гэж хэлсэн. Энэхүү тодорхойлолт нь Матайг Сайнмэдээнийхээ энэ хэсгийг түлхүүр асуултаар эхлүүлэхэд хүргэсэн. Матай 18:1 дээрээс бид энэ тухай харж болно. Энд:

“—Тэнгэрийн хаанчлалд хэн хамгийн агуу нь байх вэ? ” гэжээ (Матай 18:1).

Есүс энэ асуултад заавар бүхий зүйрлэл, сургаалт зүйрлэлээр дамжуулан дөрвөн үндсэн хэсэгт хуваан хариулсан. Эхлээд Есүс 18:2-4 дээр дагалдагч нартаа бяцхан хүүхдүүдийн адил даруу амьдрахыг ятгасан.

Дайснуудын эсэргүүцэл улам гаарч байгаа тэрхүү нөхцөлд Есүс тэднийг Бурханы хүүхдүүд болохынхоо хувьд тэнгэрийн хаанчлалд хэрхэн амьдрахыг заасан. Тэрээр хаанчлалын ирээдүйн бүрэн төгс байдал хараахан ирээгүй байгааг мэдэж байв. Мөн Тэрээр дайснууд болон нүглийн эсрэг тэмцэл нь Бурханы хүүхдүүдийн амьдралын нэг хэсэг байна гэдгийг ч мэдэж байлаа.


Мөн 5-14-р эшлэлд Тэрээр тэдэнд тэнгэрлэг Эцэг нь төөрсөн хонио хариулдгийн адил сул дорой нэгнээ халамжлахыг сургамжлав. Матай 18:10, 14-р эшлэлүүдэд энэ талаар Есүс юу гэснийг хамтдаа харцгаая. Тэрээр энд:

“Та нар энэ багачуудын нэгийг нь ч бүү басамжил. Би та нарт хэлье... Тиймд энэ багачуудаас хэн нэг нь алдагдах нь тэнгэр дэх Эцэгийн чинь хүсэл биш юм” гэжээ (Матай 18:10,14).

Есүс Матай 18:15-20 дээрх санаанд тулгуурлан хэдий нүгэл нь тэдний харилцааг тасалдуулсан ч Бурханы гэр бүлийн гишүүдийн ёсоор бие биетэйгээ харьцахыг тэднээс шаардсан. Мөн 21-35-р эшлэлд Тэрээр нүгэл үйлдсэн “ах дүүгээ” тэнгэрлэг Эцэг нь уучилсны адилаар тэд ч бас уучлах ёстой гэжээ.

Бурхан олон агуу үйлсийг үйлдэж, газар дээрх хаанчлалаа тэлсээр байгаа тул Бурханы алдар бидний үед ч улам өсөн нэмэгдсээр байна. Гэхдээ Есүсийн үетэй адил Бурханыг эсэргүүцэгсэд ч мөн нэмэгдсээр байна гэсэн үг юм. Талархалтай нь зовлон, бэрхшээл, сорилт дунд Бурхан бидэнд туслах олон үнэт бэлгийг өгдөг. Эдгээр бэлгүүдэд тэсвэр тэвчээр, амар амгалан, тэр ч байтугай Түүний бидэнтэй хамт байх оршихуй ч ордог. Мөн хамгийн онцгой бэлгүүдийн нэг бол бидний Эцэг болох Бурхантай харилцах харилцаа мөн. Бурхан биднийг халамжилж, хамгаалдаг бөгөөд бидний сул талыг ойлгож, өрөвддөг. Мөн Тэрээр бидэнд үйлчилж, биднийг хайрлаж чадах хүмүүн гэр бүлийг буюу чуулганыг, Бурханы гэр бүлийн ах, эгч, дүүсийг өгдөг.

Одоогийн Эсэргүүцэл ба Ирээдүйн Ялалт



Матайн Сайнмэдээний тав дахь үндсэн хэсэг нь тэнгэрийн хаанчлалын өнөөгийн эсэргүүцэл ба ирээдүйн ялалтын тухай байдаг. Энэхүү хүүрнэл нь 19:1–22:46 хүртэл үргэлжилдэг бөгөөд Есүс амьдралынхаа энэ үед хэрхэн асар их эсэргүүцэлтэй тулгарсныг харуулдаг.

Эрчимжиж буй Эсэргүүцэл

Эдгээр бүлгүүд Есүсийн үйл хөдлөлд үндэслэн үндсэн гурван хэсэгт хуваагддаг. 19:1–20:16 дээр Есүс Иудейн нутагт эсэргүүцэлтэй тулгарсан тухай бий. Тэнд Тэрээр фарисайчуудтай ярилцаж, гэр бүл салалтын талаарх асуудлаар нүүр тулсан байдаг. Мөн Тэрээр эд баялаг, эрх мэдлийн талаарх буруу ойлголтоос үүдэлтэй эсэргүүцэлтэй тулгарч байв.

Сайнмэдээнийхээ эхэн хэсэгт Матай Есүс болон Иудейн удирдагчдын хоорондох хурцадмал байдлын талаар тэмдэглэсэн байсан шүү дээ. Одоо энэ хэсэгт тэрээр энэ нь бүрэн дайсагнал болсныг харуулдаг. Жишээлбэл, фарисайчууд заримдаа Есүсээс өө эрэн Түүнийг унагах асуултууд тавьж байлаа. Энэ талаар Матай 19:3-9; 21:16, 23 болон 22:15-40-р эшлэлүүдэд дурдсан нь бий. Зөвхөн нэг жишээ болгон энэ талаар Матай 22:15 дээр юу гэснийг хамтдаа харцгаая. Тэрээр энд:

“Тэгээд фарисайчууд явж, Есүсийг хэлсэн үгэнд нь яаж унагаахаа хамтдаа зөвлөлдөв” гэсэн байдаг (Матай 22:15).

Үүний зэрэгцээ Есүс Иудейн удирдагчдыг заримдаа сорьж шалгаж байв. Үүнийг 21:28–22:15 дээрх хоёр хүү, олиггүй түрээслэгчид, хурим найрын талаарх сургаалт зүйрлэлээс бид харж болно.

Гэхдээ энэхүү зөрчилдөөн ганцхан яриа төдий байсангүй. Зарим тохиолдолд Есүс мөнгө солигчдын ширээг хөмрүүлж, сүмээс хөөж гаргах зэрэг шууд, хүчтэй арга хэмжээ авч байсныг Матай 21:12-16 дээрээс харж болно. Ялангуяа 23:13-35-р эшлэл дэх долоон золгүй еэ гэх Түүний үгс мөн энэ зөрчилдөөний тод илрэл байлаа. Матай 23:15 дээр Есүс тэднийг хэрхэн зэмлэснийг сонсоцгооё:

“Хоёр нүүрт хуулийн багш нар ба фарисайчууд та нар золгүй еэ! Та нар ганц хүний араас ч болов тэнгис, газаргүй хөндлөн гулд явсаар шинэ итгэлтэн болгохдоо түүнийг өөрсдөөсөө хоёр дахин дор тамын хүү болгодог аж” гэжээ (Матай 23:15).

Мэдээж хэрэг Есүс болон Иудейн удирдагчид л эдгээр бүлэг дээрх цор ганц дүрүүд байсангүй. 21:1-11 дээрх Есүс Йерусалимд сүр жавхлантайгаар орж ирэхэд олон түмэн Түүнийг хүндэтгэсэн нь Иудейн удирдагчдын дайсагналыг улам дэвэргэв.

Энэ хэсгийн туршид Есүс уг зөрчилдөөнийг өөрсдийн холч хараа болгохыг дагалдагч нартаа уриалж байлаа. Матай 19:27-30 дээр Тэрээр нэг өдөр тэд Түүнтэй хамт сүр жавхланд нь түүнтэй хамт суух болно хэмээн амласан. Гэвч 20:17-19 дээр Тэрээр мөн эдгээр сүр жавхлант өдрүүд нь зөвхөн Өөрийнх нь зовлонт үхлийн дараа ирэх болно гэдгийг сануулсан.

Түүгээр ч барахгүй дагалдагч нар нь зовлон дотор даруугаар амьдарсны дараа л энэхүү сүр жавхланд хүрэх болно гэдгийг Есүс хатуу хэлсэн. Есүс энэ ойлголтыг гурван удаа эргэн сануулсан байдаг. Матай 19:30 дээр Есүс хэлэхдээ:

“Харин эхэнд байгаа олон нь сүүлчийнх, сүүлчийнх нь эхнийх болох

болно” гэжээ (Матай 19:30).

Тэгээд мөн Матай 20:16 дээр Тэрээр:

“Тиймээс сүүлчийнх нь эхнийх болж, эхнийх нь сүүлчийнх байх болно гэж айлдав” гэсэн байна (Матай 20:16).

Түүнчлэн Матай 20:26-28 дээр Тэр үүнийг ийнхүү давтжээ:

“Та нарын дунд ийм юм бүү байг. Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог. Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд бас олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ гэв” гэжээ (Матай 20:26-28).

Есүсийн хаанчлал хачин жигтэй санагдана. Түүний дагалдагчид зовох болж, Израилын хаан Өөрөө ард түмнийхээ гарт алагдах болно. Ялалтын өмнө илэрхий ялагдал хүлээх аж.

Эрчимжиж буй эсэргүүцлийн дараагийн хэсэг нь Есүс Йерусалим руу явах үед болсныг бид 20:17-34 дээрээс харж болно. Зовж бас үхэхийн тулд Йерусалим руу явж байгаагаа Есүс тодорхой хэлсэн. Хөвгүүддээ хаанчлалд нь эрх мэдэл өгөхийг хүссэн хоёр дагалдагчийнх нь ээжээс Тэр мөн л эсэргүүцлийг хүлээн авав. Дараа нь түүнийг Йерусалим руу ороход нь хурсан олон угтан авлаа. Ийнхүү сүр жавхлантайгаар орж ирснээрээ тэрээр Хуучин Гэрээний эш үзүүллэгийг биелүүлсэн юм.

Дараагийн хэсэг буюу 21:12–22:46 дээр Есүс Йерусалим болон сүмд орж, гарахдаа эсэргүүцэлтэй тулгарсаар байв. Тэрээр мөнгө солигчдыг хөөж, Бурханы ирэх шүүлтийн талаар сэрэмжлүүлсэн сургаалт зүйрлэлүүдийг ярьжээ. Түүгээр ч барахгүй, Есүс болон шашны удирдагчдын хооронд Цезарьд төлөх татвар, үхэгсдийн амилал, хамгийн агуу тушаал, Мессиа хэний хүү байсан талаар теологийн маргаан өрнөж байв.

Харин Есүс тэдгээр эсэргүүцэгчдийг хэлэх үггүй болгож байжээ. Энэ талаар Матай 22:46-р эшлэлд өгүүлдэг. Тэрээр энд:

“Хэн ч Түүнд хариу хэлж чадаагүй бөгөөд тэр өдрөөс хойш нэг ч хүн Түүнээс юм асууж зүрхэлсэнгүй” гэжээ (Матай 22:46).

Ингээд бид Матайн хүүрнэлээс тэнгэрийн хаанчлалыг эрчимтэй эсэргүүцэж байсан тухай үзэж судаллаа. Харин одоо бид үүнийг дагалдсан яриаг авч үзэх хэрэгтэй.

Ирээдүйн Ялалт

Энэ хэсэг нь Матай 23:1–25:46 хүртэл үргэлжилдэг. Энэ яриандаа Есүс

тэнгэрийн хаанчлалын ирээдүйн ялалтыг дүрсэлсэн.

Уг хэсэг нь Матай 23:1-38-р эшлэлээр буюу эсэргүүцэгчдийнхээ эсрэг тунхагласан долоон “золгүй еэ” үгсээр эхэлдэг. Энэ яриа нь ялангуяа фарисайчууд, тэдний худал сургаал, Бурханы ард түмнийг хүчирхийлж, хоёр нүүр гаргадаг явдалд голлон анхаардаг.

Энэ ярианы төгсгөлд буюу Матай 23:37-38-р эшлэлүүдэд Есүс Йерусалимын талаар ийнхүү дүгнэв:

“Йерусалим аа, Йерусалим аа, эш үзүүлэгчдийг алж, өөр лүү нь илгээгдэгсдийг чулуугаар нүүлгэдэг хот оо. Тахиа дэгдээхэйнүүдээ далавчин дороо бөөгнүүлдэг шиг Би хүүхдүүдийг чинь цуглуулахыг хэчнээн ч удаа хүслээ дээ. Харин та нар хүсээгүй. Харагтун, гэр чинь та нарт хоосон үлдэж байна” гэжээ (Матай 23:37-38).

Есүсийн ярианы дараагийн хэсгийг ихэвчлэн Чидун уулын Яриа гэж нэрлэдэг бөгөөд энэ нь Матай 24:1–25:46 хүртэл гардаг. Есүс эдгээр үгсийг Чидун уулан дээр дагалдагч нартаа хэлсэн тул үүнийг ихэвчлэн Чидун уулын Яриа гэж нэрлэдэг.

Чидун уулын Яриаг үндсэн гурван хэсэгт хувааж болно. Матай 24:4-28 дээр Есүс тэнгэрийн хаанчлал хэдийнээ ирсэн боловч алдар ба хүч чадал нь хараахан бүрэн илчлэгдээгүй байгаа энэ эриний төрөх өвдөлтийн талаар дүрсэлсэн байдаг. Мөн 24:29-31 дээр Тэрээр хаанчлалын бүрэн байдлын тухай өгүүлж, Хүний Хүү үүлэн дээр залран, тэнгэрийн хаанчлал бүх хүч ба алдар дотор ирэх өдрийг зөгнөсөн. Дараа нь 24:32–25:46 дээр Есүс тэрхүү сүр жавхлангийн өдөр хэзээ болохыг хэн ч мэдэхгүй тул хүмүүсийг анхаарал сэрэмжтэй байхыг сануулсан.

Ямар ч байсан Есүс Өөрийг нь хэзээ буцаж ирэх хугацааг нь нарийн тодорхойлох гэж оролдохгүй, тодорхой цаг хугацааны хүрээнээс хэтрүүлэхгүй байх ёстойг Тэрээр зориудаар тодруулж өгсөн байна. Түүний буцаж ирэх өдөр, цагийг хэн ч мэдэхгүй гэж Тэр хэлэв. Тэр ч байтугай Өөрийн хүмүүн чанараараа байх үедээ Өөрөө хэзээ буцаж ирэх цагаа мэдээгүй. Тиймээс бид таамаглаж, үүнийг цаг хугацааг нарийн тооцоолох гэж оролдох нь зүгээр л Есүст дуулгаваргүй байгаа явдал болдог. Гэхдээ энэ нь Түүний хоёр дахь ирэлт ойртож буйг сануулж, тэсэн ядан хүлээж, тэр ч байтугай шинж тэмдгүүдийг нь эрэн хайх хэрэггүй гэсэн үг биш юм. Христийн хоёр дахь ирэлтийн талаарх Шинэ Гэрээний сургаалын гол зорилго нь юуны түрүүнд биднийг сэрэмжлүүлэх, урам зориг, итгэл найдвар өгөх, ариун амьдрал руу хөтлөх, Христийн эргэн ирэлтийг хүлээх явдал байдаг. Тиймээс бид яг цагийг нь мэдэхгүй ч гэсэн Түүнийг буцаж ирэхэд нь ямар ч үед бэлэн байх ёстой. Ингэснээр бид Түүнийг хүсэн тэмүүлж, баяртайгаар угтан авах болно.

— Др. К. Эрик Тоеннес

Түүнийг эргэж ирнэ гэдэгт бид бүрэн итгэлтэй байх хэрэгтэй. Түүнийг дахин ирж, эхлүүлсэн бүхнээ гүйцээх болно гэдэгт бид бүрэн итгэлтэй байх ёстой. Бид ч гэсэн үнэнч байх хэрэгтэй. Үйлс 1-р бүлэгт Есүсийг явсны дараа тэд тэнгэр өөд ширтэн байтал тэнгэр элч “та нар юунд тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нар Сайнмэдээг үндэстнүүдэд хүргэх үйл хэргээ гүйцэтгэх ёстой” гэсэн шиг сануулгыг хүлээн авах ёсгүй. Тэр эргэж ирнэ, гэхдээ бид Агуу Захирамжийг биелүүлээд завгүй байж байх хэрэгтэй. Бид Хаан ирчихсэн гэдгийг үндэстнүүдэд тунхаглан хүргэж, өөрсдийн Хаандаа үйлчлээд завгүй байх хэрэгтэй. Тэр дахин ирэх болно. Гэмшиж, Сайнмэдээнд итгэгтүн. Есүс Христэд итгэдгээ өчиж хаанчлалд орж буй хүмүүсийг Бурханы алдрын төлөө, Түүнд нийцүүлэн амьдардаг болгон өсгөн, дагалдуулах хэрэгтэй. Бид амьдралынхаа бүхий л талбарт Бурханы алдрын төлөө амьдрах хэрэгтэй. Ингэхдээ Түүний ирэхийг ширтэн харж, чуулгантай хамтдаа эрин үе бүрд “Ирээрэй, Эзэн Есүс ээ” хэмээн хэлнэ.

— Др. Стивен Ж. Вэллум

Матай Сайнмэдээнийхээ тав дахь үндсэн хэсэгт Иудейн удирдагчид Есүсийг үгүйсгэж, бүр Түүнийг алахаар төлөвлөж байсан тухай өгүүлсэн. Гэвч тэдний дэлхий дээрх бүхий л төлөвлөгөө нь хаанчлалын ирээдүйн ялалтыг зогсоож чадахгүй гэдгийг Тэрээр тодорхой хэлсэн. Мөн Түүний зөв байсныг түүх ч нотолдог. Иудейн удирдагчид Түүнийг алсан. Гэвч Түүний хаанчлал бүхий л цаг үеийн туршид тэлсээр л ирсэн. Түүх нэг л өдөр сүүлчийн хэсэг нь ч мөн зөв гэдгийг батлах болно. Есүс Өөрийн хаанчлалыг бүрэн дүүрэн авчирч, үнэнч итгэмжит хүмүүсээ хаанчлалын ерөөлөөр шагнахаар хүч чадал, агуу сүр жавхлангаар дахин ирэх болно.

ЕСҮСИЙН ҮЙЛЧЛЭЛИЙН ОРГИЛ ҮЕ



Матайн Сайнмэдээний хүүрнэлийн дүгнэлт нь Матай 26:1–28:20 хүртэл үргэлжилдэг. Энд Матай Есүсийн баривчлагдсан, цовдлогдсон, үхлээс амилсан зэрэг нь мессиа Хааны үйлчлэлийн нь оргил үе гэж дүрсэлсэн байдаг.

Бид Матайн Сайнмэдээний дүгнэлт хэсгийг судлахдаа Матай дээрх хаанчлалтай холбоотой гурван сэдвийг судлах болно. Эдгээр нь зөрчил тэмцэл, дагалдагч байх болон ялалтын тухай байна. Эхлээд зөрчил гэсэн сэдвийн хүрээнд хамтдаа харцгаая.

Зөрчил

Есүсийн авчирсан хаанчлал нь үнэндээ Иудейчүүдийн хүсэн хүлээсэн Мессиагийнх нь авчрах хаанчлалаас тэс өөр байсан. Тиймээс энэ нь тэднийг Есүс болон Түүний хаанчлалтай шууд зөрчилдөхөд хүргэсэн. Бидний харж байгаагаар Матайн Сайнмэдээний туршид энэхүү зөрчил улам ширүүссэн авч энэ хүүрнэлийн дүгнэлт хэсэгт оргил цэгтээ хүрдэг. Жишээлбэл, Есүсийн эсрэг иудейчүүдийн хуйвалдааны тухай 26:3-4 дээрээс, Түүнийг баривчлах, шүүх талаарх тэдний нууц төлөвлөгөөг 26:14-16, 47, 57-68 зэрэг хэсгүүдээс, мөн Түүнийг цовдол цовдол хэмээн хашхирч буй талаар 27:20-25-р эшлэлээс тус тус харж болно. Тэгээд Иудейчүүд өөрсдөө Есүсийг цовдолсныхоо хариуцлагыг хүлээн авах үед энэ нь оргилдоо хүрдэг. Энэ талаар Матай 27:25 дээр юу гэснийг сонсоцгооё. Энд:

“Тэгтэл бүх хүн —Түүний цус бидний ба үр хүүхдүүдийн маань дээр байг гэцгээв” гэжээ (Матай 27:25).

Дараа нь Есүс загалмай дээр зовж байхад Иудейчүүд Түүнийг тохуурхаж, Израилын мессиа Хаан гэж тунхаглан дооглож байжээ. Матай 27:41-42-р эшлэлээс бид энэ тухай харж болно. Энд:

“Ахлах тахилчид ч бас хуулийн багш нар ба ахлагчдын хамт элэглэн "Тэр бусдыг аварсан ч" "Өөрийгөө аварч чадсангүй" гэв. Тэр бол Израилын Хаан” гэжээ (Матай 27:41-42).

Егөөтэй гэмээр нь Иудейчүүд Есүсийг Бурханыг гутааж, хаан ширээнд хуурамчаар суугч гэж үзэн эсэргүүцэж байснаараа үнэн хэрэгтээ тэд өөрсдийг нь аврах эрх мэдэлтэй цорын ганц хаанаасаа татгалзсан юм.

Энэхүү зөрчлийн талаарх сэдвийн хажуугаар дагалдагч байх талаарх сэдэв нь Матайн дүгнэлт дэх хаанчлалын талаар онцлон тэмдэглэдэг.

Дагалдагч байх нь

Матай зовж буй Мессиаг дагах нь хичнээн хэцүү байсныг онцолсон. Тэрээр Есүсийн үйлчлэлийн энэ чухал мөчид Есүсийн дагалдагч нарын бүтэлгүйтлийн

талаар мэдээлэхдээ үүнийг онцолсон. Матай 26:14-16 болон 47-50 дээр Иудас Түүнээс урвасан бөгөөд 27:3-10-т энэ бүтэлгүйтлээсээ болж амиа хорлосон тухай нь өгүүлдэг. Петр, Иаков, Иохан нар 26:36-46 дээр буюу Гетсеманид Түүнтэй хамт сэрүүн байж чадаагүй. Мөн 26:69-75 дээр Есүсийг мэддэг гэдгээ ч Петр удаа дараа үгүйсгэсэн байдаг. Эцэст нь буюу 26:56-р эшлэлд Есүсийн бүх дагалдагч нар Түүнийг орхисон тухай тэмдэглэжээ.

Үнэндээ бол Есүсийг дагах нь тун хэцүү хэрэг байв. Бид зовсон мессиа Хаанд итгэдэг бөгөөд Тэр биднийг бас зовлонд дуудсан. Хэрэв бид Түүнд үнэнч байвал бид ч гэсэн зовлон, бэрхшээлийг амсаж, гэмд соригддог. Тэнгэрийн хаанчлал бүрэн дүүрэн байдлаараа хараахан ирээгүй байна. Үүнээс болоод Христитгэлийн амьдрал нь олон талаараа байх ёстой хэмжээндээ хүрээгүй байна.

Зөрчил ба дагалдагч байх сэдвүүдийг авч үзсэн тул одоо бид хаанчлалын ялалтын сэдвийг судлахад бэлэн боллоо.

Ялалт

Ялалтын сэдэв нь Есүсийн амилал дээр тодорхой харагддаг бөгөөд энэ нь мессиа Хаан ард түмнийхээ бүх дайснуудыг, тэр байтугай үхлийг ч ялан дийлсэн гэдгийн баталгаа юм. Мөн бид Есүсийн тэнгэр өөд одохоосоо өмнө хэлсэн сүүлчийн үгсээс ялалтын тухай олж уншдаг. Матайн Сайнмэдээнд бичигдсэн Есүсийн эцсийн үгс Матай 28:18-20-р эшлэлд байдаг бөгөөд үүнийг бид Агуу Захирамж гэж нэрлэдэг. Эдгээр нь Эзэний дагалдагч нартаа өгсөн эцсийн заавар бөгөөд Түүнийг явсны дараа үйлчлэлийг нь хариуцах томилгоо байв. Энэхүү заавар нь Христ хаанчлалын бүх эрх мэдлээ зоригтойгоор тунхаглан эхэлж байгаа нь анхаарал татдаг. Матай 28:18 дээрх Есүсийн тунхаглалыг сонсоцгооё. Тэрээр энд:

“—Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” гэсэн байдаг (Матай 28:18).

Есүс бол бүх ноёрхол, бүх хүчийг хууль ёсны дагуу авч чадах цорын ганц Нэгэн юм. Дашрамд хэлэхэд Түүний хүч чадал нь хүч, хайр учраас сүйтгэгч чанартай биш. Хайраас урсан гарах хүч. Хайраар л хэрэгждэг хүч юм. Тэгэхээр чамд зөвхөн хайр л байвал сайхан тааламжтай мэдрэмж төрнө. Гэхдээ чамд юуг ч өөрчлөх хүч байхгүй бол ямар ч нэмэргүй байж магадгүй юм. Хэрэв та хайргүй, зөвхөн хүч чадалтай бол устгаж, алж, үзэн ядна. Энэ бол хайр ба хүчийг хамтад нь нэгтгэдэг Бурханы суу ухаан юм. "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул Хүүгээ өгсөн." Тэрээр энэ дэлхий дээр амьдарч байсан боловч хэзээ ч нүгэл үйлдээгүй, худал хэлж, хуурч мэхлээгүй цорын ганц Нэгэн. Тиймээс Тэр бол бүх эрх мэдлийг хууль ёсны дагуу авч чадах цорын ганц Нэгэн мөн. Тэр бас алагдсан, үхсэн, оршуулагдсан, эргэж ирсэн цорын ганц Нэгэн. Тиймд Тэр бол амилсан Эзэн. Энэ бол хүн төрөлхтний түүхийн шинэ эриний эхлэл үе юм. Тэр үндэстнүүдэд итгэл найдварыг

авчирч байна. Тиймээс, Бурханы хаанчлал маш хүчирхэг арга замаар ажилласаар байна. Дэлхийн Сайнмэдээ түгээлт, үндэстнүүдийг дагалдуулах нь үүн дээр л тулгуурладаг. Үүнийг би "агуу суурь" гэж нэрлэдэг. Агуу суурьгүйгээр агуу захирамж гэж үгүй. Тэгээд Тэрээр "Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно" гэсэн агуу амлалтаар дуусгадаг. Тиймээс, Эзэн Есүс, Хаан Есүс бол бүх хүчийг эзэмшигч захирагч юм. Тиймээс бид Түүний хүчээр явж, дагалдагч болгон, зааж, тунхаглаж байдаг.

— Др. Петр Кузьмич

Бүх эрх мэдэл нь байлдан дагуулан ялсан хаанд хааных байв. Иудейчүүд Түүнийг үгүйсгэж, Ромчууд Түүнийг цовдолж, тэд бүгд Түүнийг тохуурхав. Гэвч булш Түүнийг хорьж чадаагүй бөгөөд амилал нь мессиа Хааны агуу ялалт байлаа. Түүгээр дамжуулан тэнгэрийн хаанчлал дэлхийд ирсэн. Энэ бол Матайн Сайнмэдээн дэх сайхан мэдээ нь билээ.

Одоо бид Матайн Сайнмэдээний түүхэн нөхцөл болон бүтэц ба агуулгыг судаллаа. Одоо бид Матайн онцолсон зарим гол сэдвүүдийг авч үзэхэд бэлэн болжээ.

ГОЛ СЭДВҮҮД

Хичээлийн энэ хэсэгт бид Матайн Сайнмэдээнийхээ туршид онцолсон хоёр чухал сэдэвт анхаарлаа хандуулах болно. Эдгээр нь Есүсийн хаанчлал ба Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өв, Есүс хаанчлалаа зориулан авчирсан Бурханы хүмүүс гэсэн сэдвүүд юм.

Есүсийн хаанчлал ба Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өвийг Матай хэрхэн онцолсныг эхлээд авч үзэцгээе.


Хуучин Гэрээний Өв

Матайн Сайнмэдээ бол Хуучин Гэрээнд Есүс Христийн ирэлтийг урьдчилан хүлээж байсан нь хэчнээн ач холбогдолтой болохыг бодитоор харуулсан гайхалтай түүх юм. Есүс гарч ирсэн бөгөөд Түүнийг биежсэн Израил гэж хэлж болно. Тэр Египетээс гарч, цөлд хөтлөгдөн ирж, соригдсон. Тэр ууланд гарч, хүмүүст Хуулийг дахин хүргэсэн. Шинэ Мосе буюу биежсэн Израилын эдгээр бүх дүр нь Хуучин Гэрээнээс эхтэй байдаг. Учир нь Бурхан Израилыг дуудаж, сонгох үед энэ нь хэзээ ч зүгээр л нэг сэтгэл ханамжтай жаргах онцгой завшаан байгаагүй юм. Энэ нь гүйцэтгэх үүрэг хариуцлага байсан бөгөөд үндэстнүүдэд ерөөл болох явдал байв. Гэвч гэм нүглийнхээ урт удаан, адармаатай түүхийн улмаас

Израил нь дуудагдсан зорилгынхоо дагуу өөртөө болоод өрөөлд ч ерөөлийг авчирч чадаагүй юм. Тиймээс Есүс энд Бурханы Хүү, биежсэн Израилын хувьд гарч ирсэн. Тэгээд Тэрээр Израилын гүйцэлдүүлж чадаагүй зүйлсийг нь гүйцэлдүүлэхээр ирсэн юм. Энэ нь Есүсийг энд, тэнд буй эшлэлээс олж харахаас илүүтэйгээр Хуучин Гэрээнд Түүнийг хэрхэн урьдаас зөгнөж байсныг нь илүү нарийн, гүнзгий унших боломжийг бидэнд олгодог гэж би боддог. Энэ бол тэр чигтээ Израилын түүх юм. Энэ бол Израилыг сонгосон тухай юм. Энэ бол Есүсийн ирэлтийг урьдаас зөгнөсөн Израилын бүтэлгүйтэл юм. Матай үүнийг ялангуяа эхний тав, зургаан бүлэгтээ ойлгуулсан.

— Др. Марк Гигниллиат

Хамгийн гол нь Библийн түүх бол Бурхан ард түмэнтэйгээ Өөрийгөө хайрын салшгүй утсаар холбосон тухай юм. Энэ бол ерөөл дотор тэдэнтэй хамт байх амлалтаа биелүүлсэн Түүний үнэнч итгэмжит байдлын түүх юм. Тийм учраас Матай



Матай Есүс хэлсэн үг, үйлчлэлийг дэмжихийн тулд Хуучин Гэрээг итгэлтэйгээр эш татаж байлаа.

Есүс болон үл итгэгч Иудей удирдагчдын хоорондох зөрчилдөөн, мөн Есүсийн даруу, дөлгөөн байдал зэрэг орно. Матай дээрх Хуучин Гэрээний эш таталтууд ба зүйрлэлүүдээс эхэлцгээе.

тухайн үеийн Бурханы ард түмнийг эртний амлалтуудад итгэхийг, мөн Бурхан одоо ч Есүсийн бодгаль дотор ажиллаж байгаа гэдэгт тэд итгэж болно гэсэн юм. Тийм ч учраас Матай мессиа Хаан Есүс Христийн хэлсэн үг, үйлчлэлийг дэмжихийн тулд Хуучин Гэрээг байнга итгэлтэйгээр эш татаж байлаа.

Бид Есүсийн хаанчлал ба Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өвийг харуулсан Матайн таван арга замыг товчхон авч үзэх болно. Үүнд Матайн Хуучин Гэрээнээс эш татсан эшлэлүүд болон зүйрлэлүүд, тэнгэрийн хаанчлалыг онцолсон байдал, Есүсийг мессиа Хаан гэсэн тайлбар,

Эш таталт ба Зүйрлэл

Матай Хуучин Гэрээг бусад Сайнмэдээний бичээчдээс илүү олон удаа эш татсан байдаг. Эрдэмтэд Матай нь Хуучин Гэрээг яг хэдэн удаа эш татсан талаар маргадаг ч дор хаяж 40 удаа эш татаж, өөр олон хэсэгт далд утгаар өгүүлсэн байдаг.

Матайн нэг стратеги нь "гэж хэлүүлсэн нь биелэгджээ" гэсэн хэллэгийг нийтлэг ашигладаг байв. Матай энэ хэллэгийг Хуучин Гэрээ болон Есүсийн амьдралын үйл явдлуудыг холбохдоо ашигласан.

Жишээлбэл, үүний нэг жишээг Матай 8:17 дээрээс харж болно. Энд:

“Ийнхүү эш үзүүлэгч Исаиагаар «Тэр бидний сул дорой байдлыг авч, Өвчин зовлонг маань үүрсэн» гэж хэлүүлсэн нь биелэгджээ” гэжээ (Матай 8:17).

Хуучин Гэрээнээс ийнхүү эш татахаасаа өмнөхөн Матай Есүсийн эдгээсэн олон гайхамшгуудын талаар дурдсан байдаг. Гэвч тэрээр уншигчдадаа Есүсийг зөвхөн эдгээгч гэж л харуулахыг зорьсонгүй. Харин тэрээр Есүс Хуучин Гэрээний амлалтуудыг биелүүлж, хүмүүсийг эдгээсэн гэдгийг мэдээсэй хэмээн хүссэн.

Матайн хэлэхийг хүссэн өнцөг болоод бидний харах ёстой өнцөг бол Бурханы ард түмний хүсэн хүлээж байсан хаанчлал нь Есүс дотор биеллээ олж илчлэгдсэн явдал мөн. Тэд Мессиа нь түүхэн газрын зураг дээрх тодорхой зөгнөлийг биелүүлнэ гэж хайж байсангүй. Харин тэд эрх чөлөө, чөлөөлөлт, сэргэлт, авралыг хүсэн хүлээж байв. Мөн Хуучин Гэрээ тэдэнд Бурханы хаанчлал ирэх үед үүнийг Мессиа гэх тодорхой хүн үүнийг тунхаглана хэмээн заасан байдаг. Тэгээд ийнхүү тунхагласнаар Бурханы хаанчлал эхэлж, Хуучин Гэрээнд амласан бүх сэргэлт, аврал, ерөөлүүд биеллээ олно гэжээ. Тиймээс элч нар, тэр дундаа Матай нь эдгээр бүх зөгнөлийг хэн биелүүлснийг зүгээр л хараад суугаагүй. Харин тэд үйлс, сургаал, зан чанар гээд бүхий л зүйл нь Бурханы хаанчлалыг илчилж буй Нэгэнийг үзжээ. Үнэн хэрэгтээ Бурханы хаанчлал Есүс дотор байсан юм. Тэрээр хаанчлалыг зарлан тунхаглаад зогсохгүй хаанчлалыг авчирсан. Тиймээс, Есүсийн хүч, сургаал, үйлсийг нь хараад Матай болоод бүх элч нар нь Түүнийг урьдаас хэрхэн зөгнөж байсныг харахын тулд Хуучин Гэрээ рүүгээ буцсан юм. Мөн тэд Хуучин Гэрээгээ Есүсийн амьдрал, үйлчлэлтэй харьцуулан уншихдаа уг Бичвэрүүд нь үнэн хэрэгтээ Есүсийг, онцгойлон Түүнийг л гэрчилсэн болохыг олж мэдэв. Тиймээс бид Хуучин Гэрээг уншихдаа үүнийг зүгээр нэг үнэт эдлэлийн томруулдаг шилээр унших ёсгүй. Харин Сайнмэдээнүүдийн гол субъект буюу Бурханы хаанчлалын биежилт ба гэрч болох Христэй Өөртэй нь уулзахын тулд унших хэрэгтэй.

— Пастор Майкл Ж. Глодо

Матай Есүсийн талаарх Хуучин Гэрээний өвийг онцолсон хоёр дахь арга нь тэнгэрийн хаанчлалыг онцолсон явдал байдаг.

Тэнгэрийн Хаанчлал

Хуучин Гэрээнд Бурхан ард түмнээ ерөөнө гэж амласан. Мөн Түүний ерөөл

Давид хааны удмын Хүүгээр дамжин ирэх болно гэв. Есүс доторх Бурханы хаанчлалын ерөөл нь эртний эдгээр амлалтуудын биелэл гэдгийг Матай зарлан тунхаглав.

Матайн Сайнмэдээнд Есүс Өөрөө эдгээр үнэнийг хүмүүст сануулсаар байсан. Бурхан Хуучин Гэрээний хаанчлалын амлалтууддаа үнэнч гэдгийг Тэрээр тогтмол зааж байжээ. Хэдийгээр энэ нь үхэл зовлонд хүргэж, Хуучин Гэрээнд эш үзүүлсэн бүхнийг хийгээгүй ч ийнхүү Тэрээр хаанчлалаа өнөөх сайхан мэдээ гэдгийг харуулж байлаа. Есүс хүмүүсээс Өөрийг нь *эхлүүлснээ дуусгаж*, Бурханы амласан *бүхнийг* бүрэн гүйцэлдүүлнэ гэдэгт итгэлтэй байхын тулд Хуучин Гэрээн дэх Бурханы үгэнд бүрэн итгэх ёстой гэж байсан юм.

Үнэн хэрэгтээ Тэнгэрийн хаанчлалын тухай Хуучин Гэрээний дүр зурагт итгэх энэхүү итгэл нь Есүс дагалдагчдаа Хуучин Гэрээг сахиж, итгэж найдахыг байнга сануулдаг байсан үндэс суурь байв. Энэ нь Бурханы хаанчлалын элэг нэгт иргэдийн хувьд бие биеэ хайрлаж, үйлчлэхийг тэдэнд зааварласан үндэс суурь мөн.

Тэнгэр газрын Бурхан бүх түүхийг удирдаж, амлалтдаа үнэнч байдаг гэсэн мэдлэг нь бүх үеийнхэн, тэр дундаа энэ бидний үеийнхэн Христэд өгсөн амлалтууд нь сайн хэвээр байгаа гэдэгт итгэхэд нь түлхэц өгөх ёстой. Нэг өдөр Бурхан бүх зүйлийг шинэ, зөв болгоно гэдэгт итгэхэд бидэнд тэдгээр нь онгод оруулж нөлөөлөх ёстой. Мөн Бурхан хаанчлалаа бүрэн дүүрэн авчрахыг тэвчээртэй хүлээх үед тэдгээр нь бидэнд хүч чадал, тэсвэр тэвчээрийг өгөх ёстой.

Есүсийн хаанчлал болон Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өвийг онцолсон гурав дахь арга бол Есүс нь хүлээж буй мессиа Хаан байсан гэдгийг батлах явдал юм.

Мессиа Хаан

Бид хичээлийнхээ эхэнд Есүсийн угийн бичгийн талаар ярилцахдаа энэ санааг дурдсан. Энэ нь Матай Есүсийг "Давидын Хүү" гэж бусад Сайнмэдээний бичээчдээс илүү олон удаа дурдсанаас нь харагддаг. Мөн Иудейн Хаан, Израилын Хаан, чиний Хаан, зүгээр л Хаан зэрэг бусад олон хааны цолыг Есүст зориулан Матай ашигласан. Түүнээс гадна тэрээр Есүсийг хаан хэмээн дуудсан зарим эшлэлүүд нь өөр ямар ч Сайнмэдээний номд байдаггүй. Жишээлбэл, Матай 2:2 дээр тэрээр мэргэдийн асуусан асуултыг тэмдэглэсэн байдаг. Энд:

“Саяхан мэндэлсэн, иудейчүүдийн Хаан хаана байна? ” гэжээ (Матай 2:2).

Өөр ямар ч Сайнмэдээ энэ эшлэлд энэ эшлэл байдаггүй. Өөрөөр хэлбэл Есүсийг мессиа хаан гэдгийг онцлоогүй байдаг.

Есүсийн хаанчлал болон Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өвийг онцолсон дөрөв дэх зүйл бол Есүсийн үл итгэгч Иудей удирдагчидтай зөрчилдсөн явдал юм.

Үл итгэгч Иудей Удирдагчид

Матайн анхны уншигчид Есүс Израилын олон удирдагчидтай зөрчилдсөн нь Түүнийг Мессиа биш гэдгийг нотолсон байна хэмээн буруугаар бодох боломжтой байв. Тэдэнд ийм сэтгэгдэл төрүүлэхгүй байхын тулд Матай Иудейн удирдагчдын итгэлгүй байдлыг үл харгалзан Бурхан Есүсээр дамжуулан амлалтаа биелүүлж байгааг тодорхой болгож харуулсан.

Есүс фарисайчууд болон хуулийн багш нарын сургаалыг удаа дараа үгүйсгэж байв. Тэрээр Матай 9:14-17 дээр мацаг барих талаар, 12:13 дээр Амралтын өдрийн тухай, 15:1-20 дээр гар угаах талаарх тэдний үзэл бодлыг засаж залруулсан байдаг. Мөн Уулан дээрх сургаалын ихэнх хэсэг, ялангуяа 5:17-48-р эшлэлд Бурханы хуулийн талаарх Иудейн үзлийг Есүс уг хуулийг биелүүлсэн гэдэгтэй харьцуулсан байдаг.

Заримдаа хүмүүс Есүс Уулан дээрх сургаалдаа "... та нар ингэж айлдсаныг сонссон, харин Би та нарт хэлье..." гэснийг нь хараад энэ нь Хуучин Гэрээнд хэлсэнтэй зөрчилдөж байгаа биш үү гэж гайхдаг. Гэхдээ миний бодлоор үүнийг унших хамгийн ойлгомжтой арга гэж бий. Энэ нь Есүс Бурханы яг айлдсан Хуучин Гэрээний хуулийг олон үеийн туршид янз бүрийн гүүш, хуулийн багш нар тайлбарласаар ирсэн тайлбаруудыг нь няцаасан гэдгийг мэдэх явдал юм. Мөн Есүс Өөрийгөө Бурханы хуулийг зөв тайлбарлаж чаддаг Нэгэн, төдийгүй үүнд бичигдсэн зүйлсийг хүлээн авч, Өөрийн үеийн сонсогчдод хэрэгжүүлдэг Нэгэн гэдгийг мэдүүлж байлаа.

— Пастор Др. Саймон Виберт

Есүс Уулан дээрх сургаалдаа "... та нар ингэж айлдсаныг сонссон, харин Би та нарт хэлье..." гэсэн хэллэгийг ашиглахдаа Тэрээр Хуучин Гэрээний хууль одоо хүчингүй болж байна гэж ер хэлээгүй. Үнэндээ Тэр бүр эсрэгээр нь "Хуулийг биелүүлэхийн тулд Би ирсэн юм" гэж маш тодорхой хэлсэн. Гэвч Есүс Хуулийн багш нар өөрсдийн заах эрх мэдлийн талаар ярихдаа ашигладаг байсан рабби нарын нийтлэг арга барилыг ашигласан юм. Энд "та нар уламжлалын дагуу хуулийн талаарх сургаалуудын талаар ингэж айлдсаныг та нар сонссон, харин Би та нарт хэлье, ..." гэсэн байдаг. Энэ нь одоогийн эрх мэдэл болоод нэмэлт эрх мэдэл хамтдаа байгаа нь харагдана. Тиймээс Есүс энэхүү олонд танигдсан заах арга техникээр Өөрийн сургаалын эрх мэдлийг тогтоож байна. Тэрээр Хуучин Гэрээний Хуулийг үл тоосондоо бус, харин теологийн болон Христологийн хувьд маш чухал зүйлийг хэлэхийг зорьсон юм. Энэ нь "Хуучин Гэрээний хуулийг Надтай

болон Миний Хуулийн талаарх сургаалтай холбон тайлбарлах нь чухал" гэдгийг харуулах явдал байлаа.

— Др. Грегори Р. Пэрри

Үгүй ээ, Есүс Хуучин Гэрээтэй ер зөрчилдөөгүй. Гэвч Матайн Сайнмэдээнээс бидний харж буй сэдвүүдийн нэг бол Есүс нь шинэ Мосе байсан гэдэг нь юм. Тэрээр Мосегоос ч илүү агуу юм. Тиймээс Бурханы эрх мэдэл бүхий үг болох Хуучин Гэрээний илчлэл нь Мосегоор дамжуулан бидэнд ирсэн. Харин Есүс Хуулийг тайлбарлах бүрэн эрхтэй нэгэн болж байгааг харж болно. Дээрх сургаал дээрх ихэнх зүйлс Мосегийн хэлснийг үнэн зөв тайлбарлаж байгаа нь тодорхой харагдана. Тиймээс Есүс “Бүү ал” гэсэн тушаалыг хүчингүй болгосонгүй. Тэр зүгээр л аллага нь уур хилэнт зүрхнээс эхэлдэг гэдгийг л бидэнд тайлбарладаг. Энэ хэсэг хэрхэн эхэлдгийг санаарай? Есүс хуулийг “Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин биелүүлэхийн тулд Би ирсэн юм” гэж хэлсэн нь хуулийг зөв тайлбарлах гэсэн утгатай гэж би боддог. Гэхдээ Есүсийн маргаж байгаа зүйл бол хуулийн жинхэнэ зорилгыг бодитоор биелүүлэх тухай байна гэж харагддаг. Энэ хуулийг Есүс Христийн ирэлт, Түүний үхэл, амилал болон Түүний үйлчлэлтэй нь уялдуулан тайлбарлах ёстой. Харин бид Түүнийг ийнхүү ойлгох үед Есүс Хуучин Гэрээний хуулийг хүчингүй болгодоггүй, харин Тэр үүнийг биелүүлдэг гэдгийг ухаарна.

— Др. Томас Р. Шрайнер

Есүс Хуучин Гэрээний мессиагийн талаарх хүлээлтүүдийг үнэхээр биелүүлсэн. Гэвч Иудейчүүдийн хүлээлт нь Хуучин Гэрээний үзэлтэй бүрэн нийцэхгүй байсан тул олон Иудейчүүд Есүсээс татгалзсан. Мөн тэд ийнхүү буруу ойлгосон нь Есүсийг дагах гэж хичээж буй бүх хүмүүст анхааруулга болдог. Бурханы ажил ямар харагддаг талаарх өөрсдийнх нь санаа бодлууд бидний харааг бүрхэг болгохдоо тун амархан гэдгийг тэд бидэнд анхааруулдаг. Бурханы хийж чадах зүйлд зохиомлоор хязгаарлалт тавихгүй, харин бидний итгэл найдвар, хүлээлтүүдийг тодорхойлохыг Түүнд зөвшөөрөх ёстойг тэд бидэнд анхааруулдаг.

Есүсийн талаарх Хуучин Гэрээний өвийг онцолсон тав дахь арга бол Есүсийн даруу, дөлгөөн байдлыг дүрсэлсэн явдал юм.

Даруу ба Дөлгөөн байдал

Есүсийн үеийн Иудейчүүд Хуучин Гэрээнд заасны дагуу Бурхан ард түмнээ аврах хүчирхэг дайчнаа илгээнэ гэдгийг зөв зүйтэй ойлгосон байв. Гэвч Бурханы агуу аврал чөлөөлөлт нь ард түмнээ гэсэн Түүний даруу дөлгөөн хүсэл тэмүүлэлд

үндэслэгдсэн байсныг Матай онцолсон. Мөн тэрээр үүнийгээ Хуучин Гэрээнээс эш татан тайлбарлаж байна.

Жишээлбэл, Матай 11:29 дээр Есүс хүнд дарамт үүрсэн хүмүүсийг ийнхүү урьсан байдаг. Энд:

“Би зүрх сэтгэлдээ дөлгөөн бөгөөд даруу тул буулгыг минь өөрсөд дээрээ авч Надаас суралц. Тэгвэл та нар сэтгэлдээ амралтыг олох болно” гэжээ (Матай 11:29).

Энд Мессиа ард түмнээ амраах болно гэдгийг батлахын тулд Есүс Иеремиа 6:16-р эшлэлээс эш татсан. Үүний нэгэн адил Матай 12:15-21 дээр Матай Есүсийн энэрэнгүй эдгээх үйлчлэлийн талаар өгүүлж, Есүсийн юу хийж байгааг тайлбарлахын тулд Исаиа 42:1-4-р эшлэлийг эш татсан. Матай 12:19-20 дээрх Есүсийн тайлбарыг сонсоорой. Тэрээр энд:

“Тэр мэтгэлцэхгүй, хашхирахгүй Гудамжнуудад хэн ч дууг нь сонсохгүй. Тэрээр шударга ёсыг ялалтад хүргэтэл Бяцарсан зэгсийг хугалахгүй, Бүдгэрсэн дэнг бөхөөхгүй” гэжээ (Матай 12:19-20).

Иудейчүүд өөрсдийг нь Ромын эсрэг тулалдаанд удирдан чиглүүлэх чанд хатуу тулаанч хааныг хүсэн хүлээж байлаа. Гэвч Есүс яг тэр хүссэн хаан шиг нь байсангүй. Харин оронд нь даруу дөлгөөн, өрөвч энэрэнгүй Нэгэн байлаа. Хуучин Гэрээний дагуу Матай Есүсийг байлдан дагуулагч Хаан, Бурханы ард түмний эрх мэдэлтэй багш гэж дүрсэлсэн. Үүний зэрэгцээ Есүс бол даруу төлөв, өрөвч энэрэнгүй Хаан гэдгийг тэрээр онцолжээ. Өөрсдийн амьдрал, үйлчлэлд Есүсийг дагах дуудлага маань Есүсийн үлгэрлэн харуулсан энэрэнгүй сэтгэлээр үнэнийг ярихыг бидэнд уриалдаг.

Есүсийн хаанчлал болон Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өвийг олон янзын арга замаар Матай онцолсон. Үүний зэрэгцээ Матай нь Есүс эртний бүх хүлээлтүүдийг давуулан гүйцэлдүүлсэн болохыг тодорхой хэлсэн. Харин сайхан мэдээ буюу Сайнмэдээ нь Тэрээр эдгээрийг биелүүлсэн явдал байв. Есүс тэнгэрийн хаанчлалыг дэлхийд авчрах үед хаанчлал, Хууль, ялангуяа Хааны талаарх зөн өөрөө бүгд биелэгдсэн юм.

Есүсийн хаанчлал болон Сайнмэдээний талаарх Хуучин Гэрээний өвийг бид нэгэнт үзсэн тул Бурханы ард түмэн гэх сэдвийг авч үзэхэд бэлэн боллоо.

БУРХАНЫ АРД ТҮМЭН

Библийн бусад хэсэгтэй адил Матайн Сайнмэдээнд Бурханы ард түмэн бол Бурханд харьяалагддаг хүмүүс, Түүний үнэт өмч хөрөнгө, мөн Өөрөө Хаан болж захирдаг онцгой үндэстэн юм. Мөн тэд зөвхөн Бурхантай шууд харилцаатай байгаад зогсохгүй Түүнд хамаарах бусад бүх хүмүүстэй ойр дотно харилцаатай байдаг.

Бид Бурханы ард түмэн гэх сэдвийг гурван хэсэг болгон судлах болно. Нэгдүгээрт, Матай Бурханы ард түмнийг чуулган гэж тодорхойлсон гэдгийг бид харах болно. Хоёрдугаарт, тэр тэднийг мөн “Бурханы гэр бүл” гэснийг үзнэ.

Гуравдугаарт, Бурханы ард түмний Есүсээс хүлээн авсан дуудлагыг бид тус тус судална. Ингээд Чуулган бол Бурханы ард түмэн гэсэн ойлголтыг эхлээд авч үзэцгээе.

Чуулган

Хуучин Гэрээнд Израил нь Бурханы ард түмэн байсан. Гэхдээ Шинэ Гэрээнд Бурханы ард түмнийг ихэвчлэн “чуулган” гэж нэрлэдэг. Манай орчин үеийн “чуулган” гэсэн нэр томъёо нь Матай дээр *ἐκκλησία* гэх грек үг байдаг. Хуучин Гэрээний Грек орчуулга болох Септуагинтад *ἐκκλησία* гэдэг нь *кахал* гэдэг еврей үгийн орчуулга юм. Энэ нь Еврей Хуучин Гэрээнд ихэвчлэн Израилын ард түмний цугларалт эсвэл чуулганыг хэлдэг байв. Израилын ард түмний “цугларалт” гэдгээс Христитгэлийн “чуулган” болж үгийн утга шилжсэн нь Есүс, Матай хоёр хоёул Христийн чуулганыг Израилын ард түмний цугларалтын үргэлжлэл гэж үздэг байсныг харуулдаг.



Есүс, Матай хоёр хоёул Христийн чуулганыг Израилын ард түмний цугларалтын үргэлжлэл гэж үздэг байсныг харуулдаг.

Хуучин Гэрээн дэх *кахал* буюу “цугларалт” гэсэн еврей үгийн хэрэглээг авч үзье. Израилын ард түмнийг Леви 16:33, Тооллого 16:47, Шүүгчид 20:2, болон Дуулал 22:22 зэрэг эшлэлүүдэд “цугларалт” гэж тодорхойлсон байдаг. Үнэн хэрэгтээ, Бурханы ард түмний цугларалт Хуучин Гэрээнд маш чухал байсан. Учир нь энэ нь эш үзүүлэгч Иоел Бурханы ард түмэн эцсийн өдрүүдэд сэргээгдэх болно хэмээн эш үзүүлэхдээ Израилтай адилтган хэрэглэсэн нэрсийн нэг байв. Иоел 2:16 дээр Тэрээр ийнхүү тунхагласан. Энд:

“Ард түмнийг цуглуулж, чуулганыг ариусга” гэжээ (Иоел 2:16).

Энэ эшлэлийн еврей эх хувилбарт "чуулган/цугларалт" гэж орчуулагдсан үг нь *кахал* юм. Гэхдээ Грек хэл дээрх Септуагинтын орчуулгад энэ үг нь *ekklesia* буюу Шинэ Гэрээнд ихэвчлэн "чуулган" гэж орчуулагддаг. Матай 16:18 дээр Есүсийн хэлсэн үгсийг дурдахдаа Матай нэг ижил хэллэгийг ашигласан. Тэрээр энд:

“Би чуулганаа босгох болно” гэжээ (Матай 16:18).

Энд Есүс Өөрийн чуулганыг, өөрөөр хэлбэл эцсийн өдрүүд дэх мессиагийн цугларалт буюу *кахал*-ыг босгоно гэсэн Иоелын эш үзүүлэгийг давтсан харагддаг.

Есүс Матайн Сайнмэдээнд Өөрийн чуулганаа босгоно гэж хэлсэн. Грек Шинэ Гэрээн дэх чуулган гэсэн үг болох *эkklesia* нь Бурханы ард түмний цугларалт болох *кахал* гэсэн Хуучин Гэрээний санааг илэрхийлэхэд ашигладаг Грек үг гэдгийг санах нь сайн эхлэл болдог. Ингэснээр Хуучин гэрээний Бурханы ард түмний цугларалтын үргэлжлэл нь Шинэ гэрээний чуулган болдог.

— Пастор Майкл Ж. Глодо

Есүсийг мессиа Хаан хэмээн тунхаглахтай зэрэгцэн эсэргүүцэл улам бүр нэмэгдэж байсан. Үүнийг бид Матай 16-р бүлэгт гарч буй үйл явдлуудаас хэдийнээ олж харсан. Энэхүү эсэргүүцэл нь Есүс дагалдагч нараа Израилын цугларалттай адилтган урамшуулсан шалтгаануудын нэг юм. Тэрээр мессиагийн цугларалт буюу чуулганаа байгуулах төлөвлөгөөнд нь тэднийг итгэлтэй байхыг хүссэн юм.

Есүсийн үг нь бас чуулган Түүнийх гэдгийг маш тодорхой харуулсан. Энэ нь Петрийнх биш байв. Энэ нь Израилынх ч биш байсан. Энэ нь бас зөвхөн гишүүд нь л эзэмшдэг ардчилсан байгууллага ч биш байв. Энэ бол Мессиагийн чуулган байсан юм. Энэ талаар Иосефт тэнгэрэлч юу гэсэн талаар бичихдээ Матай нь Сайнмэдээнийхээ оршил хэсэгт хэдийнээ хэлсэн байжээ. Матай 1:21 дээр энэ тухай өгүүлдэг. Энд:

“Тэрээр Хүү төрүүлнэ. Чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэрээр ард түмнээ нүглээс нь аварна” гэжээ (Матай 1:21).

Энэ эшлэлд Есүсийг төрөхөөс өмнө тэнгэрэлч Иосефт Мариагийн хэвлий дэх хүүхэд бол Бурханы бүх ард түмэн харьяалагдах Мессиа мөн гэдгийг батлан өгүүлжээ. Тэр тэдний хаан байсан бөгөөд тэд Түүний ард түмэн байв.

Тиймээс бидний хувь хүн бүр зөвхөн Есүсийн дагалдагчид биш юм. Бид бол Түүний Өөрийнхөө амиллаараа, мөн шинэ сүм болгон сүнснийг өгснөөрөө авчирсан шинэ бүтээлийнх нь биежилт юм. Тиймээс бид хүмүүс өршөөл ба уучлалыг, дутагдах үедээ хангамжийг, ганцаардсан үедээ нөхөрлөлийг олж чаддаг чуулган

буюу Бурханы хаанчлалын оршихуйг тээгчид болсон юм. Тиймээс чуулган бол үнэндээ нэг л өдөр бүх бүтээлд харагдахуйц болох шинэ тэнгэр, газрын амталгаа билээ.

— Пастор Майкл Ж. Глодо

Бурханы ард түмэн дарлалд орж, амьдралын үйл явдлууд нь тэднийг доош унагаахаар заналхийлэн, харанхуй тэднийг нөмрөн авах яг тэр үед Есүс “Би чуулганаа босгоно, Би мессиагийн цугларалтаа босгох болно” гэж хэлдэг. Тэр бол бидний Хаан бөгөөд бидний төлөө хамгийн сайныг төлөвлөж, эцэст нь биднийг гарцаагүй аварч, ерөөх болно гэдгээ баталдаг Нэгэн юм. Уг явдал энэ амьдралд тохиолдохгүй байж ч мэднэ. Гэхдээ энэ нь биелэх л болно. Үүнд бид итгэлтэй байж болно.

Матай нь Бурханы хүмүүсийг чуулган гэж тодорхойлохоос гадна Бурханы гэр бүл гэж тодорхойлсон.

Бурханы Гэр бүл

Матайн Сайнмэдээнд Бурханы ард түмэн Өөртэй нь болон бие биетэйгээ харилцах харилцааг дүрслэхдээ “аав”, “хүү”, “ах дүү” гэх мэт гэр бүлтэй холбоотой хэллэгийг 150 гаруй удаа ашигласан байдаг. Гэр бүлийг илэрхийлэх хэллэгийг байнга ашигладаг өөр нэг Сайнмэдээний бичээч бол Иохан юм. Гэхдээ Иохан үүнийг ашиглахдаа Есүс болон Түүний тэнгэрлэг Эцэгийн хоорондын харилцааны тухай ихэнхдээ өгүүлдэг байв.

Үүний эсрэгээр Матай үүнийг Бурхан ба Түүний ард түмний хоорондын харилцааны тухай өгүүлэхдээ ашиглажээ. Тэр Бурханы гэр бүлийн тухай ярьж байлаа. Юуны өмнө Матай энэ нэршлээр Бурханы хүүхдүүдээ үзүүлж буй халамж, хамгаалалтыг онцлон тэмдэглэхийг зорьжээ. Жишээлбэл, Матай 6:4-р эшлэлд ард түмэндээ үзүүлдэг Бурханы хайр халамжийн талаар Есүс ингэж өгүүлсэн. Тэрээр энд:

“Энэ нь өглөг чинь нууц байхын тулд бөгөөд нууц харагч Эцэг чинь чамд буцааж төлнө” гэсэн байна (Матай 6:4).

Мөн тэрээр 6 болон 18-р эшлэлд энэ хэллэгийг дахин ашигласан. Түүний санаа нь Бурхан хүүхдүүдээ анхаарал тавьж, тэднийг урамшуулан хангах зорилготой байсан гэв.

Матай 6:8 дээр Есүс дагалдагч нартаа хэрхэн залбирахыг заахдаа оршил болгон ийнхүү хэлжээ. Энд:

“Эцэг чинь та нарт юу хэрэгтэйг гуйхаас чинь өмнө мэддэг” гэжээ (Матай 6:8).

Бурхан биднийг ерөөж, бидний залбирлыг сонсоно гэдэгт бид итгэлтэй байж болно. Яагаад гэвэл Тэр бол биднийг хайрладаг Эцэг гэдгийг бид мэддэг.

Би сүнслэг байгуулалтын хичээл заадаг л даа. Тэгэхээр Эзэний залбирлын талаар миний хэлдэг нэг зүйл бол ямар ч мөчид нэгэн зэрэг залбирч байгаа сая сая хүмүүс байж болно гэдгийг мэдэж, залбирлаа эхлүүлэх явдал юм. Бидний Бурханыг "Бурхан" гэж дуудах нэг шалтгаан нь Тэрээр эдгээр залбирал бүрийг хүлээн авч, тухайн мөчид залбирал бүрд анхаарч чаддагт оршино. Гэвч энэ нь биднийг тэнгэрийн хаанчлалыг бий болгодог ариун нөхөрлөл рүү авчирдаг. Яг үүний дараа мэдээж "Аав" гэдэг үг байдаг. Тэгэхээр би хэн ч байсан, хаана ч байсан залбирал дотор Бурханыг Абба буюу Аав аа хэмээн ирдэг. Хэрэв Польшид хэн нэгэн Бурханыг "Аав аа" гэж дуудаад, би энд Америк-д Бурханыг "Аав минь" гэж дуудаж байгаа бол бид ах, эгч дүүс гэсэн үг. Хэрэв бид нэг аавтай бол бид нэг гэр бүлийн гишүүд болно. Тиймээс Матай үүнийг тэнгэрийн хаанчлалын үзэл баримтлалыг илэрхийлэх хүчтэй арга зам гэж үзсэн. Тэгээд л энэ үгийг дахин дахин ашигласан гэж би боддог. Гэхдээ залбирал нь намайг залбирч байгаа тэр мөчид надтай ижил зүйлийг хэлж байгаа бусад хүмүүстэй хамт залбирч байгааг ойлгуулдаг. Тэд миний хэлж байгаа зүйлийг хэлж байгаа бол бид нэг гэр бүл гэсэн үг.

— Др. Стив Харпер

Бурхан биднийг Өөрийн гэр бүлдээ үрчилж авсан гэх үнэнийг бодохоос илүү урам өгөх зүйл гэж үгүй. Уучлагдах нь агуу зүйл боловч Ж.И.Пакер *Бурханыг мэдэхүй* номдоо зөвтгөгдөх нь бас агуу зүйл. Гэхдээ Бурханы гэр бүлд үрчлэгдэх нь бүр ч агуу зүйл хэмээн дурдсан байна. Бурханыг бид өөрийн аав болгох нь үнэндээ бидний амьдрал дахь Бурханы ажлын оргил цэг юм. Бид зөвхөн шүүгчээр уучлагдаад зогсохгүй, Бурханы гэр бүлд үрчлэгдсэн, Тэр бол бидний Аав, бид Түүний хүүхдүүд. Тиймээс бид Христтэй хамт өв залгамжлагчид болсон. Есүст ирэх бүх зүйлс, бүх юмс нь биднийх юм. Энэ нь бидний өв билээ. Бид зүгээр л уур хилэнгийн хүүхдүүд байсан. Бидний хүртэх өв нь Бурханы уур хилэн л байв. Одоо харин бид уур хилэн биш, Христтэй хамт өв залгамжлагчид болсон байна. Бид бурханлаг мөн чанарыг хуваалцагчид бөгөөд Христийн ах дүүс гэж дуудагддаг. Бидний бохир хувцас Түүний зөвт байлаар солигдсон билээ. Тэгээд үүн дотор бид Бурханы хүүхдүүд болж, Түүний гэр бүлд уригдсан. Энэ бол бидний төсөөлж чадах хамгийн агуу ерөөл билээ.

— Др. К. Эрик Тоеннес

Матай 6:25-34 дээр Бурхан хүүхдүүддээ анхаарал халамж тавьдаг гэдгийг

батлахын тулд Есүс хоёр өөр жишээг ашигласан. Тэрээр "тэнгэрийн шувууд" болон "хээрийн сараана цэцэг" хоёрын тухай ярьж, Бурхан Өөрийн бүтээлийн хамгийн өчүүхэн нэгний хэрэгцээг хүртэл хангадаг гэдгийг онцолсон. Хэрэв Бурхан тэдгээрт санаа тавьдаг бол Тэр ард түмэндээ илүү их санаа тавих нь дамжиггүй. Тэнгэрлэг Эцэг маань биднийг илүү сайн хоол хүнс, хувцас хунар, хамгаалалтаар хангах болно.

Есүс дагалдагч нартаа үйлчлэлийн үлэмж зовлон бэрхшээлийн талаар сануулахдаа Бурхан Эцэгийн халамж, хамгаалалтыг ч мөн онцолсон. Жишээлбэл, 10:19-20-р эшлэлд Есүс тэднийг баривчлагдах болно гэжээ. Харин Тэр бас Эцэгийн Сүнс тэдэнтэй хамт байх болно гэж хэлсэн. Үйлчлэлээсээ болж амь насанд нь аюул учирвал Эцэг нь тэднийг хамгаалах болно гэдгийг тэдэнд сануулсан юм. Матай 10:29-31 дээр буй Есүсийн урам зоригийн үгсийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Хоёр бор шувууг задгай зоосоор худалддаг бус уу? Эцэгийн чинь зөвшөөрөлгүйгээр тэдний нэг нь ч газарт унахгүй... Тиймээс бүү ай! Та нар олон бор шувуунаас ч эрхэм үнэтэй” гэжээ (Матай 10:29-31).

Олон итгэгчдийн хувьд Христитгэгч байх нь маш хэцүү гэдэг. Дэлхийн олон газар хавчлагад өртөж байна. Мөн тэдний амьдралын агуу баяр баясгалан нь тэд биеийн нэг хэсэг бөгөөд өөрсдийгөө Бурханы ард түмэн гэж дуудаж чаддаг байх явдал юм. Бурхан бол бидний Аав гэдгийг Бичвэр бидэнд хэлдэг. Бидэнд Ром 8-р бүлэгт дурдсанчлан, Бурханыг Абба хэмээн дуудах асар онцгой эрх бий. Бурхан биднийг байнга халамжилж байдаг гэх бодит үнэн ч мөн бидэнд бий. Бурхан гэр бүлийнхээ гишүүдэд хайраа харуулдаг гэдгийг бид бас харж байна. Тиймээс, итгэгчдийн хувьд тэдний амьдралын гол цөм нь Христээр дамжуулан ирдэг урам зориг юм. Учир нь Бурхан одоо бидний Аав юм.

— Др. Жефф Лоуман

Бурханы ард түмэн бол Бурханы чуулган ба гэр бүл гэдгийг үзсэн тул одоо бид Бурханы ард түмний дуудлагын талаар судлахад бэлэн болжээ.

Дуудлага

Бурханы ард түмэн бол Түүний чуулган, гэр бүл нь байх онцгой их хувь тохиол юм. Гэвч Түүний ард түмэн гэх бидний дуудлагад зовлон, бэрхшээл, аюул занал мөн багтдаг. Есүс Өөрөө бол бидний зовлон амссан мессиа Хаан билээ. Түүнийг дагаснаар бид ч мөн зовдог. Тухайлбал, Матай 10:34-36 дээр Есүс бидний дуудлага нь зөрчлийг дагуулдаг гэж хэлсэн. Тэрээр энд хэлэхдээ:

“Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү бод. Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм. Хүүг эцгийнх нь эсрэг,

Охиныг эхийнх нь эсрэг, Бэрийг хадам эхийнх нь эсрэг болгохын тулд Би ирсэн. Хүний дайсан нь гэр бүлийнхэн нь болно” гэжээ (Матай 10:34-36).

Мөн Матай 16:24-25 дээр Тэрээр ийнхүү тайлбарласан:

“Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ олно” гэсэн байна (Матай 16:24-25).

Хүмүүс Өөрийг нь үгүйсгэсэн шиг ард түмнийг нь ч мөн үгүйсгэх болно гэдгийг Есүс мэдэж байлаа. Хааны маань хувьд зовлон нь сүр жавхлангийн зам байв. Мөн бидний хувьд ч адил юм.

Загалмай дээр хүмүүс Түүнийг тулаанд ялагдлаа л гэж бодсон байх. Булшинд ороход нь хүртэл Түүнийг ингээд дууслаа даа л гэж бодсон биз. Гэвч гурав дахь өдрийн өглөө юу болох ёстойг тэд мартаж орхисон. Есүс "чи энэ биеийг хөнөө, Би гурав хоногийн дараа амилах болно" гэж хэлсэн. Тиймээс бид чуулган нь хэрхэн гадуурхагдаж, шүүмжлүүлж, гутаан доромжлуулж байгааг бодоходоо Есүсийн хэлбэржүүлсэн чуулган болон өнөөгийн чуулган нь нэг ижил болохыг ойлгодог. Энэ нь маш их тэсвэрлэж, маш их юман дундуур гарсан ч байсаар байгааг хараарай. Ахиад жаахан цааш харья л даа. Есүс Христийн Сайнмэдээ, махбод болж ирсэн Үгийг тэд тэр үед алж чадаагүй бол одоо ч алж чадахгүй. Тиймээс, бид Түүний нэг хэсэг ... бид бол чуулган, Түүний чуулган юм шүү дээ. Түүнийг юу ч, тэр байтугай тамын үүд ч зорилгыг нь зогсоон, дийлэхийг Тэрээр зөвшөөрөхгүй. Энэ чуулган нь зорилготой бөгөөд уг зорилго нь дэлхий даяар явж, төөрсөн хүмүүсийг авралд авчран, дагалдагч болгох явдал юм. Энэ нь юутай их баяр хөөр вэ? Чуулган хадгалан хамгаалагдсан тул та бид хоёр одоо аюулгүй байж, амиллын хүчийг одоо ч амсаж амьдрах нь байна шүү дээ.

— Др. бага Вилли Уэллс.

Есүс ард түмнийхээ зовлонг төгсгөж, шаналлаас нь амрааж, бидний төлөө амар амгаланг тогтоож, хэмжээлшгүй ихээр ерөөхөө амласан. Гэвч энэ нь хараахан бүрэн биелээгүй байна. Түүнийг бүх зүйлийг шинэ болгохоор эргэн ирэх хүртэл бидний дуудлага бол зовж буй Хааныхаа зам мөрийг дагах явдал юм.

Есүс биднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн хэмээн хэлсэн. Гэвч бид энэ амьдралдаа Эзэн Есүс Христийг таньж мэдсэнийхээ дараа ч зовлон, шаналал, өвчин эмгэгийг мэдэрсэн хэвээр байж, үхлийг ч амсдаг. Бидэнд урам хугарал ч, бардам хүсэл

ч байсаар байна. Бид уур бухимдлыг, мөн уй гашууг ч мэдэрсээр байна. Бидний эндээс ойлгож авах ёстой нэг зүйл бол энэхүү бялхам амьдралыг хүлээн авахын нэг хэсэг нь эдгээр бэрхшээлийн дунд Христтэй хамт байх явдал гэдгийг та мэдэж байгаа биз ээ. Хэрэв бид хэзээ ч уурладаггүй, урам хугардаггүй байсан бол Христигтэлийн амьдралдаа олон чухал зүйлсийг ойлгож авах боломжгүй байсныг ухаарна. Бид уй гашуу, баяр хөөр, баяр баясгаланг амсаагүй байсан бол хэзээ ч мэдэхгүй л байх байлаа. Энд үнэхээр ямар нэг чухал зүйл байгаа гэж би боддог. Есүс “Харин Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн билээ” гэж хэлсэн. Гэхдээ мэдээж бид ямар нэг зүйлийг хүсэж тэмүүлдэг. “Христ дотор” байхын нэг утга нь Түүний авчрах бүрэн дүүрэн байдлыг хүсэн тэмүүлэх явдал юм. Христ чуулгандаа ирэх өдөр айсуу байна. Христ бүгдэд харагдахуйц байдлаар бүхнийг хаанчлах өдөр ирж байна. Бурхан Эцэгийн алдрын төлөө өвдөг бүр сөгдөж, хэл бүхэн Есүс Христ бол Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрөх өдөр ирж байна. Уйлах нь үгүй болж, нулимс бүр арчигдах өдөр ирж байна. Христ дотор бялхам амьтай байна гэдэг нь чухамдаа бид Христ дотор амарч, амьдралд хийгээд унасан энэ ертөнцөд ирэх бүх баяр баясгалан, зовлон бэрхшээлийг туулахдаа айсуу зүйл маань ирж буйг тэсэн ядан хүлээх явдал юм. Бялхам амь гэдэг нь Христийг ирэх хүртэл Түүнд итгэсээр байхыг хэлнэ.

— Др. бага Р. Альберт Мохлер.

ДҮГНЭЛТ

Матайн Сайнмэдээг судлахдаа бид түүхэн нөхцөлийг нь бичээч, анхны хүлээн авагчид ба нөхцөл байдал гэсэн хэсгүүдэд хуваан үзлээ. Ингэхдээ бид бүтэц ба агуулгыг нягтлан харж, Хуучин Гэрээнд буй өвийнх нь гол сэдвүүд болон Бурханы ард түмнийг онцолсон байдлыг нь авч үзсэн.

Матайн Сайнмэдээнд тэнгэрийн хаанчлалын талаарх Хуучин Гэрээний амлалтууд нь мессиа Хаан болох Есүсийн бодгаль болон үйлсээр нь биелсэн гэх сайхан мэдээг тунхагладаг. Мөн уг сайхан мэдээ нь Есүс бидний төлөө болон биднээр дамжуулан Өөрийн хаанчлалаа үргэлжлүүлэн барьж, байгуулсаар байгаа явдал юм. Гэвч энэ нь үргэлж амар хялбар байдаггүй. Бидний үзсэнчлэн Матай нь зовлон амссан мессиа Хааныг дагах бидний дуудлагыг эрс шулуухан дүрсэлсэн. Гэвч тэрээр мөн тэнгэрлэг Эцэгийн ерөөлүүдийг ч эрс шулуун дүрсэлсэн юм. Ингэхдээ эдгээр ерөөлүүд нь биднийг Хаанаа үнэнчээр дагаж, тэнгэрийн хаанчлал нь алдар дотор бүрэн дүүрнээр ирэх хүртэл өөрсдийн зовлон бэрхшээлийг даван туулах боломжийг олгодог болохыг тайлбарласан.

ХАМТРАГЧИД

Др. Пит Алвинсон (Хөтлөгч) нь FORGE буюу “Толин тусгал дахь Эрэгтэй” гэх хот даяарх эрчүүдийн үйлчлэлийн гүйцэтгэх захирал. Тэрээр мөн Флорида мужийн Винтер Спрингс дэх Виллоу Грик Пресбитериан чуулганы (РСА) үүсгэн байгуулагч бөгөөд 26 жилийн турш Тэргүүн Пастороор үйлчилсэн нэгэн юм. Доктор Алвинсон нь Библи Судлалын магистрын зэргээ Тринити Евангелийн Дивинити сургуульд, Үйлчлэлийн Докторын зэргээ Шинэчлэлийн Теологийн Сургуульд тус тус хамгаалсан. Тэрээр Шинэчлэлийн Теологийн Сургуулийн дэд профессор, Амьдралын Түлхүүр Сүлжээний Удирдах Зөвлөлийн Гишүүн. Тэрээр *Аав шиг, Хүү шиг: Бурханыг аав шигээ мэдэх нь хүмүүсийг хэрхэн өөрчилдөг вэ?* номын зохиогч юм.

Др. Дэвид Р. Бауэр нь Асбери Теологийн Сургуулийн Индактив Библи Судлалын Ральф Валдо Бисон Профессор бөгөөд Библийн Тайллын Сургуулийн хичээлийн эрхлэгч.

Др. Стивен Чан бол Сиэтлийн их сургуулийн теологи, шашин судлалын дэд профессор.

Др. Стивен Кован нь Линкольн Мемориал Их Сургуулийн Философи ба Шашны профессор, Итгэлээ өмгөөлөхүйн Эх сурвалж Төвийн ажилтан, Бирмингемийн Теологийн Сургуульд Философи ба Итгэлээ өмгөөлөхүйн дэд профессор

Др. Марк Гигниллиат бол Бисон Дивинити Сургуулийн Хуучин Гэрээний Дивинитийн дэд профессор.

Пастор Майкл Ж.Глодо бол Флоридагийн Орlando дахь Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Пасторын Теологийн дэд профессор юм.

Др. Жеймс М. Хамилтон бол Өмнөд Баптист теологийн Сургуулийн Библийн теологийн дэд профессор, Кенвудын Баптист сүмийн номлогч пастор.

Др. Стив Харпер нь Флорида мужийн Орlando дахь Асбери Теологийн Сургуулийн Флорида-Дуннам кампусыг үүсгэн байгуулагч дэд ерөнхийлөгч бөгөөд Сүнслэг Байгуулалт, Вэсли Судлалын тэтгэвэрт гарсан профессор.

Др. Петер Кузьмич бол Гордон-Конвельин Теологийн Сургуулийн Ева Б. Пол Э. Томс нарын нэрэмжит Дэлхийн Илгээлт, Европ Судлалын хүндэт профессор бөгөөд Хорватын Осиек дахь Евангелийн Теологийн Сургуулийн үүсгэн байгуулагч, захирал.

Др. Жефф Лоуман нь Алабама мужийн Алабастер дахь Евангелийн Чуулган РСА-ийн тэргүүн пастор, Бирмингемийн Теологийн Сургуулийн Номлох ухаан ба

Системт Теологийн профессор.

Др. Жим Мэплс нь Бирмингемийн Теологийн Сургуулийн Пасторын Удирдлагын Үйлчлэлийн Докторын хөтөлбөрийн захирал.

Др. Жон Э. МакКинли бол Талбот Теологийн Сургуулийн Библи ба Теологи Судлалын дэд профессор юм.

Др. бага. Р. Альберт Мохлер нь Өмнөдийн Баптист Теологийн Сургуулийн ерөнхийлөгч.

Др. Ионатан Т. Пеннингтон нь Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Судалгааны Доктор Судлалын захирал, Шинэ Гэрээний Тайллын туслах профессор юм.

Др. Грегори Р. Пэрри нь Гурав дахь Мянган Үйлчлэлийн Стратегийн Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгч, Гурав дахь Мянган Семинарийн Ерөнхийлөгч. Тэрээр өмнө нь Ковенант Теологийн Сургуульд Шинэ Гэрээний дэд профессор, Хотын Үйлчлэлийн Санаачилгын захирлаар ажиллаж байсан.

Др. Томас Р. Шрайнер бол Жэймс Буханан Харрисоны Шинэ Гэрээний орчуулгын профессор ба Өмнөд Баптист Теологийн Семинарт Бичвэр ба орчуулгын эрхлэгч

Др. Марк Л.Страусс бол Сан Диего дахь Бетел Сургуулийн Шинэ Гэрээний профессор.

Др. К. Эрик Тоеннес нь Биола Их Сургуулийн Талбот Теологийн Сургуулийн Библи ба Теологи Судлалын профессор, Библи ба Теологи Судлалын теологийн тэнхимийн эрхлэгч.

Рев. Др. Симон Виберт бол Англи, Виржиниа Воте дахь Христийн Чуулганы туслах пастор бөгөөд Оксфорд, Вайклифе Холл дахь Номлолын Сургуулийн Дэд Ерөнхийлөгч ба Захирал асан.

Др. Петр Волкер нь Тринити Сургуулийн Библи судлалын профессор, Оксфордын Уиклиф Холлд дэд захирал асан. Одоо Библи судлалын Иерусалим Төвд багш.

Др. бага. Вилли Уэллс Алабама мужийн Фэйрфилд дэх Плезант Гроув Баптист чуулганы пастор, Бирмингемийн Теологийн Сургуулийн профессор.

Др. Стивен Ж. Вэллум бол Өмнөдийн Баптист Теологийн Сургуулийн Христэд Теологийн профессор юм.

Др. Бен III Витерингтон нь Асбери Теологийн Сургуулийн Докторын судалгааны Шинэ Гэрээний Амос номын профессор.

ҮГСИЙН ТАЙЛБАР

Беелзебүб - Мөн Беелзебүл гэж нэрлэдэг; "Чөтгөрүүдийн ханхүү" буюу Сатаны өөр нэг нэр

екклесиа – "цугларалт", "Бурханы ард түмэн", "чуулган" гэсэн утгатай Грек үг (галиг)

Еусебий - (МЭ 263-340 он) *Сүмийн түүхийг* бичсэн эртний Христэгч түүхч

Игнатиус - (ойр. МЭ 50-108) Чуулганы эцэг, Антиохын чуулганы гурав дахь бишоп бөгөөд эртний Христитгэгчдэд хэд хэдэн чухал теологийн сэдвүүдийг хөндсөн цуврал захидал бичсэн нэгэн

Иренаус - (ойр. МЭ 130-202 он) 2-р зууны бишоп, эртний Христитгэгч зохиолч, *Тэрсүүдийн Эсрэг* номын бичээч, Гностик үзлийг няцааж, Сайнмэдээний дөрвөн номын үнэн зөвийг баталсан нэгэн

Иосеф (мужаан) – Мариагийн (Есүсийн эх) нөхөр бөгөөд Давид хааны удам

Тэнгэрийн хаанчлал - Бурханы хаанчлалыг тодорхойлохдоо Матайн ашигласан үг хэллэг

Леви – Урьд татвар хураагч байсан элч Матайн өөр нэг нэр. Мөн тахилчаар үйлчилж байсан Израилын овог

Мессиа – "тослогдсон хүн" гэсэн утгатай еврей үг. Энэ үеэс ирэх үе рүү шилжих шилжилтийг авчрах Давидын удмын агуу хаан. Грек хэлэнд "*Христос*" гэж орчуулдаг.

Папиас - (ойр. МЭ 70-163) Эртний Христитгэлт зохиолч, Хиераполын

бишоп; Сайнмэдээ номуудын бичээчдийн талаар Еусебий түүнээс эш татсан байдаг **сургаалт зүйрлэл** – сүнслэг болон ёс суртахууны хичээл заахад ашигладаг богино ёгт түүх

Фарисайчууд – Хуулийг чанд мөрддөг гэдгээрээ алдартай 1-р зууны үеийн Иудейн шашны бүлэг. Тэд Ирээдүйн амилалд итгэдэг байсан ч Израил Хуульд дуулгавартай байх хүртэл Бурхан хөндлөнгөөс оролцохгүй гэдэгт итгэдэг

кахал – "цугларалт" эсвэл "цуглаан" гэсэн утгатай еврей үг (галиг)

Садукайчууд- Мосегийн бичсэн таван номыг (Эхлэл-Дэд хууль) л дагаж мөрддөг байсан, тэнгэрэлч, сүнс, үхэгсдийн амилалд итгэдэггүй Христийн үеийн Иудейн шашны бүлэглэл

Давидын Хүү – Мессиаг хэлдэг нэр. Тэрээр Давидын удмаас гарч, Бурханы ард түмнийг аврах удаан хүлээлгэсэн, зөвт Нэгэн. Шинэ Гэрээнд Есүсийг ийнхүү хэлдэг байсан (ялангуяа Матай номд)

синоптик - "хамтад нь харах" гэсэн утгатай нэр томъёо. Матай, Марк, Лук нарын Сайнмэдээний номуудын ижил төстэй байдлыг тодорхойлоход ашигладаг үг

Сирийн Антиох – Паул, Барнаб хоёрыг анхны илгээлтийн аянд илгээсэн Сирийн хот

Тертуллиан - (ойр. МЭ 155-230)- Эртний Христитгэлт зохиолч, Картежийн чуулганы эцэг, *Марсионы Эсрэг* зохиол бичиж, Гурвалын талаарх Латин нэр томъёог дэлгэрүүлсэн нэгэн